

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

ДҮТААР 2025 /1

ᠰᠣᠩᠭᠤᠯᠢᠢᠨ
ᠪᠣᠯᠣᠪᠰᠣᠷᠣᠯ
ᠣᠨᠣᠯ, ᠠᠷᠭᠠ
ᠵᠦᠢᠨ ᠰᠡᠲᠭᠦᠭᠦᠯ



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо

ҮНДСЭН ХУУЛТ АРДЧИЛЛЫГ
ХАМГААЛАХАД СОНГУУЛИЙН ТӨВ
БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийг эмхэтгэсэн тусгай дугаар

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Референт-хэвлэлийн төлөөлөгч

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ахлах мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Улс төрийн намын мэдээлэл, арга зүйн газрын референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн доктор, судлаач

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн тэргүүн

З.Бадмаараг

Сэтгүүлч

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн удирдах зөвлөлийн дарга

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул олшруулахыг хориглоно.

АГУУЛГА

4

НЭЭЛТИЙН ҮГ

- Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ

I ХЭСЭГ: Сонгуулийн удирдлагын байгууллагын загвар, эрх зүйн байдал, чиг үүрэг-Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо

6

Үндсэн хуульт ардчиллыг хамгаалахад Сонгуулийн төв байгууллагын гүйцэтгэх үүрэг

- Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран

12

Сонгуулийн удирдлагын байгууллагын загвар

- Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо /A-WEB/-ны Нарийн бичгийн дарга нарын газрын Харилцаа хамтын ажиллагаа, арга хэмжээ хариуцсан газрын дэд захирал Жо Жинжү,
- Харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал Ли Тэрюн,
- Харилцаа, хамтын ажиллагааны газрын ахлах судлаач Ли Инна Ким

15

ӨАБНУ-ын Сонгуулийн комиссын эрх зүйн байдал, чиг үүрэг

- Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Сонгуулийн комиссын Сонгуулийн үйл ажиллагаа хариуцсан дэд дарга Шэбури Волтэр Рамабэлэ

17

БНСУ-ын Үндэсний сонгуулийн комиссын эрх зүйн байдал, чиг үүрэг

- БНСУ-ын Үндэсний сонгуулийн комиссын Гадаад дахь сонгуулийн хэлтсийн дэд дарга Ким Сэ Хүн

20

Сонгуулийн удирдлагын байгууллагын хараат бус байдлыг хангах загвар

- Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн /International IDEA/-гийн Ахлах зөвлөх Антонио Спинэлли

II ХЭСЭГ: Сонгуулийн эрх зүй, Сонгуулийн процессын эрх зүйн хөгжлийн өнөөгийн байдал, салбар эрх зүйг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал

24

Гадаад орнуудын сонгуулийн тогтолцоо

- Академич Ж.Амарсанаа

26

Үндсэн хуулийн цэцийн хяналтын объект: Сонгуулийн ерөнхий хороо

- Хууль зүйн доктор, дэд профессор В.Удвал

32

Сонгуулийн процессын эрх зүй

- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ

37

Сонгуулийн боловсрол: чиг үүрэг, онцлог

- "Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал С.Оюунтуяа



НЭЭЛТИЙН ҮГ



Монгол Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо!

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө!

“Үндсэн хуульт ардчиллыг хамгаалахад Сонгуулийн төв байгууллагын гүйцэтгэх үүрэг” олон улсын онол практикийн бага хуралд хүрэлцэн ирсэн Та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

Ардчилал хэрхэн хөгжиж мөн бэхжиж байгаа нь нийгмийн эсвэл эдийн засгийн үзэгдлийн нэгэн адил тоон үзүүлэлтээр шууд илэрхийлэгдэж, хэмжигддэггүй боловч олон улсын байгууллага, судлаачид, эрдэмтэд тухайн улс орны парламентын хөгжил, сонгуулийн систем, түүний зохион байгуулалт, зохион байгуулж байгаа байгууллагын эрх зүйн байдал болон бусад хүчин зүйлийг шалгуур үзүүлэлтийн нэг хэсэг болгон авч үздэг.

Монгол Улс 1992 онд баталсан Үндсэн Хуулиараа эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон тунхаглан зарлаж, Монгол Улсын иргэд нийтээрээ, сайн дурын үндсэн дээр, яс үндэс, угсаа гарал, шашин шүтлэг, нас хүйс, үзэл бодол үл харгалзан, чөлөөтэй, шууд, нууц санал хураалтаар Төрийн эрх барих дээд байгууллагаа сонгох, түүнд сонгогдох эрхийг баталгаажуулсан.

1990 онд Ардын депутатын хурлын сонгуулийн хууль баталсан нь парламентын чөлөөт сонгууль явуулах анхны алхам болж анх удаа олон нам оролцож, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаа сонгосон нь ардчилсан сонгуулийн үндсийг тавьсан анхны том алхам болсон.

Сонгуулийн ямар тогтолцоог сонгож байна вэ гэдэгтэй зэрэгцүүлэн сонгуулийг өөрийн орны онцлогт нийцүүлэн хэрхэн яаж зохион байгуулж байгаа нь Ардчилсан сонгуулийн үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Сонгуулийн зохион байгуулалт, түүний ил тод байдлыг хангаж ажиллахад сонгуулийн байгууллагын бие даасан хараат бус байдал, чадавхын асуудал чухлаар тавигддаг.

Улсын бага хурлын 1992 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн тогтоолоор Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороог 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж Улсын Их Хурлын анхны сонгуулийг зохион байгуулж, явуулах түүхэн үүргийг хүлээж авсан байдаг.

Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг тус бүр 9 удаа, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох Орон нутгийн шат шатны Хурлын сонгуулийг 8 удаа зохион байгуулсан ололт амжилт, туршлагадаа үнэн дүгнэлт хийн, цаашдын хөгжлийн чиг хандлагаа тодорхойлох олон улсын онол практикийн бага хурал зохион байгуулж байгаад баяртай байна.

Энэхүү олон улсын бага хурлаас сонгуулийн төв байгууллагын хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэхэд эрх зүйн орчныг хэрхэн тодорхойлж сайжруулах хийгээд сонгуулийн процессын эрх зүйг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах санал, санаачилга гарна гэдэгт итгэлтэй байна.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

I ХЭСЭГ:

**Сонгуулийн удирдлагын
байгууллагын загвар, эрх
зүйн байдал, чиг үүрэг-
Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо**





Үндсэн хуульт ардчилсан нийгэм дэх төрийн эрх мэдэл хоорондын харилцан хяналттай, тэнцвэртэй байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалахад Үндсэн хуулийн шүүхийн хяналтын тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд энэ нь Үндсэн хуульт ёсыг хамгаалах үндсэн суурь болдог. Нийгэм, соёлын хөгжлийн нөлөөгөөр төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрт байдалд улс төрийн намын нөлөө нь хууль тогтоох үйл явц болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй байдалд зарим талаар сөргөөр нөлөөлөх эрсдэлийг хэрхэн бууруулж, зохист түвшинд хэрхэн хяналттай байлгах, хязгаарлах зэрэг олон асуудлууд нь Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэх, хамгаалах чиглэлээрх олон талт судалгааны ажлын чухал сэдэв болж байна.

Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах, бэхжүүлэх, төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахад эдгээр эрх мэдлээс шууд хамааралтай бус, өөрөөр хэлбэл хараат бус, бие даасан институтууд чухал үүрэгтэй. Тухайлбал, сонгуулийн төв байгууллага, хараат бус аудитын үндэсний байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, хүний эрхийг хамгаалах байгууллага гэх зэрэг хараат бус хэв шинжтэй байгууллагын эрх зүйн байдал, загварыг судалж, хараат бус байдлыг бэхжүүлэх нь дөрөв дэх эрх мэдлийг хөгжүүлэх, ардчилсан Үндсэн хуулийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой юм.¹

Ардчиллыг бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх гол хүчин зүйлийн нэг бол чөлөөт, шударга сонгууль юм.² Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульт ардчиллыг чөлөөт, шударга сонгуульгүйгээр төсөөлөх боломжгүй бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламентыг чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийн үндсэн дээр ард түмэн өөрсдийн итгэл үнэмшил, хараат бус, чөлөөт сонголтоороо байгуулах нь Үндсэн хуульт ардчилал оршин байгаа эсэхийг тодорхойлох нэгэн гол хүчин зүйл юм. Ард түмний сонгосон хүмүүс хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг учраас эдгээр эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн

эрх ардчилсан сонгуулийн дүнгээр улс төрийн нам, эвслийн хооронд шилждэг.³

Нөгөө талаар хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчдэд шударгаар хариуцлага тооцох, хяналттай байлгах үндсэн аргын нэг бол чөлөөт, шударга сонгууль юм. Үүнийг улс төрийн хариуцлага тооцох үндсэн механизм ч гэж үзэх нь бий. Сонгууль бол хэнд төрийн эрх мэдлийг итгэмжлэн шилжүүлэхийг шийдэх ардчилсан арга бөгөөд сонгогдсон, томилогдсон албан тушаалтанд итгэл үзүүлэх эсхүл хариуцлага тооцох хяналтын тогтолцоо юм.⁴

Иймд Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн байдал, бие даасан хараат бус байдлын эрх зүйн орчин ямар түвшинд байгаа, хараат бус байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай эрх зүйн суурийг орчныг хэрхэн нарийвчлан тодорхойлох шаардлагатай, мөн энэ нь Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэхэд ямар ач холбогдолтой талаар дүгнэж, саналаа дэвшүүлэхийг зорилго. Мөн өнөөдөр зохион байгуулж буй эрдэм шинжилгээний бага хурлын үр дүнд цаашид Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэх, хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хараат бус, бие даасан байдлыг Үндсэн хуулийн эрх зүйн хувьд дэлгэрэнгүй судлах судалгааны сэдэв болно гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улс сонгуулийн ямар тогтолцоогоор парламентын сонгуулиа явуулах шаардлагатай талаар дүгнэлт, санал, шүүмжлэлээ дэвшүүлсэн судлаачдын бүтээл, эрдмийн зэрэг гориллох бүтээл, нийтлэл олон боловч сонгуулийн ямар тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулан явуулж байгаагаас үл хамааран сонгуулийг ил тод, шударгаар явуулах сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, хараат бус, бие даасан байдлын талаар болон дотоодын болон гадаад улс орны ижил төстэй байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж буй эрх зүйн орчны талаарх дотоодын судлаачдын судалгааны бүтээл, санал,

1 Tushnet, M. (2021). "The New Fourth Branch" Institutions for Protecting Constitutional Democracy., pp. 1

2 Civic Academy South Africa. Cultivating democracy through civic education. <https://civicsacademy.co.za/what-are-free-and-fair-elections/>

3 Мөнхсайхан, О. (2023). Үндсэн хуульт ардчиллын төлөө 2013-2023, ярилцлага, нийтлэл. УБ, 198 дугаар тал

4 ХБНГУ-н Конрад Аденауэр сан. (2016). "Иргэн таны оролцоо ардчиллын баталгаа", УБ., 31 дүгээр тал

дүгнэлтүүд ховор байна.

Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид “Сонгуульд суралцахуй” бүтээлдээ⁵ Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн байдал, бүрэлдэхүүний томилгоо, орон тоо, эрх үүргийн асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн тодорхойлж, дүгнэсэн байдаг. Тухайлбал, сонгуулийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг оролцогч болон зохион байгуулагч байгууллага гэж ялгах бөгөөд, зохион байгуулагч байгууллага нь байнгын ажиллагаатай төв болон байнгын бус ажиллагаатай орон нутгийн гэж бүтцээр нь ангилсан байдаг. Мөн сонгуульд бэлтгэж, явуулах ажлыг сонгогчид өөрсдөө мэдэж зохион байгуулах боломжийг аль болохоор хангах нь ардчилсан ёсны шаардлага юм гэж дүгнэсэн байна.

Харин гадаадын судлаачид, олон улсын байгууллагаас сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдал болон сонгуулийн удирдлагын байгууллагыг Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг бүхий дөрөв дэх эрх мэдэл болох талаарх судалгааны цөөнгүй бүтээл байна. Тухайлбал:

Үндсэн хуулийн эрх зүй судлаач Марк Ташнет “Шинэ дөрөв дэх эрх мэдэл: Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах институтүүд” бүтээлдээ зарим институтын бие даасан байдлыг бэхжүүлэхгүй бол Үндсэн хуульт ардчилалд аюул учруулж болзошгүй гэж үзээд үүнд сонгуулийн үйл ажиллагаа, үр дүнд нөлөөлөх субъектив болон объектив хүчин зүйл, мөн албан тушаал, эрх мэдэл, ашиг сонирхлын төлөөх дээд болон доод түвшин дэх ашиг сонирхол, авлига, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулж болох зэрэг эрсдэл байна. Иймд аливаа улс орны сонгуулийн удирдлагын байгууллага, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, төрийн аудитын байгууллага нь Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэх, хамгаалах дөрөв дэх эрх мэдэлд хамаарах бөгөөд эдгээр институтын хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, эрх зүйн үндсэн орчныг бүрдүүлэх нь Үндсэн хуульт ардчиллыг хамгаалж буй хэрэг⁶ гэж үзжээ.

АСДҮОУХ-ийн Үндсэн хуулийн эрх зүйн салбарын олон улсын хөтөлбөрийн ахлах шинжээч Эллиот Балмер “дөрөв дэх эрх мэдлийн институтэд ардчиллын нэгдмэл, харилцан хяналттай байдлыг хангах, сайжруулах зорилготой, төрийн гурван үндсэн эрх мэдлээс хараат бус, улс төрийн хувьд төвийг сахисан төрийн байгууллагад бие даасан сонгуулийн байгууллага, үндэсний аудитын байгууллага, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, хүний эрхийн байгууллага, жендерийн эрх тэгш байдлын комисс зэрэг байгууллага багтдаг.” гэж үзсэн байдаг.⁷ Мөн уг хүрээлэнгээс Энэтхэг, БНСУ, Мексик, АНУ болон Англи зэрэг нийт 21 улс орны сонгуулийн удирдлагын байгууллагын эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийсэн “Сонгуулийн удирдлагын загварууд” судалгаа бүтээлийг 2006, 2014 эрхлэн гаргасан. Уг бүтээлд сонгуулийн удирдлагын байгууллагуудын үндсэн загварыг тодорхойлсон.

Венецийн Комиссоос 2002 онд баталсан Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1-т Сонгуулийг шударгаар зохион байгуулах бие даасан байгууллага нь сонгуулийг зохион байгуулах төв болон бусад бүх шатанд хараат бусаар байгуулагдах, мөн дүрмийн 3.1-ийн с хэсэгт зааснаар Сонгуулийн төв байгууллага нь байнгын ажиллагаатай байх ёстой гэж заасан.

Төрийн эрх мэдэл хуваарилах сонгодог онолын үндэслэгч Ш.Л.Монтескье “Хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлэх юм бол эрх чөлөө хэрэгжихгүй, шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд мөн эрх чөлөө үл оршино. Хэрэв шүүх эрх мэдэл хууль тогтоох эрх мэдэлтэй нэгдвэл иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос болж болно. Хэрэв шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгтгэвэл шүүгчид нь дарангуйлагч болох бололцоог бүрдүүлнэ.”⁸ гэж эрх мэдэл хуваарилалтын тэнцвэрийг алдагдуулах нь Үндсэн хуульт ардчиллын эсрэг ямар үр дагаварт хүргэж болох талаар тодорхой дүгнэжээ.

Үндсэн хуульт ардчилсан улс орнуудад төрийн эрх мэдлийг хуваарилах нь хэвийн үзэгдэл. Бүхий л ардчилсан үндсэн хуульд төрийн эрх мэдлийг ямар нэг хэлбэрээр хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилсан байдаг. Харин уг зарчмыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд эрх мэдэл хоорондын тэнцвэрийг хангах бие даасан, хараат бус тодорхой институт шаардлагатай болдог.⁹

Энэ ч үүднээс 21 дүгээр зууны туршид Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлж, хамгаалах шинэ институт болон түүний чиг үүргийг тодорхойлох чиглэлээр үндсэн хууль судлаачид судалгаа хийх болжээ.¹⁰ Харвардын их сургуулийн профессор, Үндсэн хууль судлаач Марк Виктор Ташнэт төрийн аль ч эрх мэдлийн салаанд хамаарахгүй, бие даасан, хараат бус институтүүдийг тодорхойлж, Үндсэн хууль захиулах, хамгаалах механизмыг гагцхүү Үндсэн хуулийн шүүхэд даатгах бус, харин өөрийн чиг үүргээ хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлж байгаа нь өөрөө үндсэн хуулийг захиулж, хамгаалах тогтолцоо болох бөгөөд энэхүү тогтолцооны эд эс болох институтүүдийг бүхэлд нь “Шинэ дөрөв дэх эрх мэдэл” хэмээн тодорхойлсон байна.¹¹

Ташнэтээс өмнө Ханс Келсен Германы парламентын хөгжлийн тухай бичихдээ эрх мэдлийн салбар хоорондын өрсөлдөөнийг тэнцвэржүүлж, тогтвортой байдлыг баталгаажуулах нь эрх мэдлийн бүтцийн дөрөв дэх үүрэг гэж үзжээ.¹² ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Эрнест-Вольфганг Бокинфёрде эрх мэдэл хоорондын тэнцвэрт байдлыг Үндсэн хуулиар хамгаалах талаар зөвхөн Үндсэн хуулийн шүүх хэмээх нэг институтыг тодорхойлоогүй бөгөөд

5 Чимид, Б. (2008) Сонгуульд суралцахуй: Тогтолцоо, үйл явц, эрх зүй, УБ., Tushnet, M. (2021). “The New Fourth Branch” Institutions for Protecting Constitutional Democracy., pp. 4
6 Bulmer, E. (2019). Independent Regulatory and Oversight (Fourth-Branch) institutions, international IDEA Constitution-Building Primer 19, pp. 6

8 Н.Лүндээжанцан. Төрийн онол. УБ., (2007), 62 дахь тал
9 Казиске, П. (2018 он). Аусбургийн их сургууль. Эрх мэдлийн хуваарилалт: Гүйцэтгэх эрх мэдэл ба шүүхийн хяналт., 1 дэх тал
10 Tushnet, M. (2019). Singapore Journal of Legal Studies, Institutions supporting constitutional democracy: Some thoughts about anti-corruption (and other) agencies, pp. 440-455 (16 pages) <https://www.jstor.org/stable/27032588>
11 Tushnet, M. (2021). The “New Fourth Branch” Institutions for Protecting Constitutional Democracy., pp.8 - 24
12 Мөн тэнд

энэ нь бүхэл бүтэн тогтолцоо болох талаар тайлбарлажээ.¹³ Зохицуулалт хийх болон хяналт тавих чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх бие даасан байгууллагууд (independent regulatory and oversight organization) нь ардчиллын чанарыг сайжруулж шударга, зарчимч байдлыг хангах, Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэх зорилготой.¹⁴ Нөгөө талаар бие даасан статустай байгууллагуудын ихэнх нь эрх мэдлийн хооронд үүсэж болох ашиг сонирхлын зөрчилдөөний тэнцвэрийг хангах тогтолцоог бий болгохын тулд байгуулагддаг.¹⁵

Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах бие даасан байгууллагуудын нэг буюу Ташнэтийн тодорхойлсон дөрөв дэх эрх мэдлийн бүрэлдэхүүн болох сонгуулийн удирдлагын байгууллага нь институтын хувьд бие даасан, бүрэлдэхүүний хувьд хараат бус байх шаардлагатай бөгөөд уг шаардлага, эрх зүйн байдлыг Үндсэн хуулиар тодорхойлох нь институтын бие даасан байдлын шалгуур үзүүлэлт болдог байна.

Энэ талаар Ардчиллын төлөөх Вестминстер сангаас сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг хэмжих индикаторыг 2020 онд боловсруулжээ.¹⁶ Тухайлбал уг судалгаанд сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг дараах гурван шалгуур үзүүлэлтээр дүгнэх боломжтой гэжээ. Үүнд:

- Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг Үндсэн хуульд тусгасан эсэх
- Сонгуулийн удирдлагын байгууллагатай холбоотой зохицуулалтууд тодорхой, хоёрдмол утгагүй эсэх
- Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн эсэх зэрэг хамаарах юм.

Сонгуулийн удирдлагын байгууллага нь институтын хувьд бие даасан, бүрэлдэхүүний хараат бус байх шаардлагатай бөгөөд институтын хувьд бие даасан байдал нь тухайн байгууллага бүтцийн, чиг үүргийн, эрх хэмжээний, нөөцийн хувьд хараат бус байх утгыг агуулдаг.

Бүтцийн хувьд бие даасан байна гэдэг нь чиг үүргээ бусад байгууллагаас үл хамаарах өөрийн бие даасан байгууллагын тогтолцоо, бүтцээр дамжуулан хэрэгжүүлж, өөр эрх мэдэлд бүтцийн хувьд хамаарах, захирагдахгүй байхыг хэлэх бөгөөд бүтцийн бие даасан байдал нь удирдлага, дотоод нэгжүүд хэрхэн бүрддэг, мөн гүйцэтгэх эрх мэдэл болон бусад төрийн байгууллагуудтай хэрхэн харилцаж байгаагаар тодорхойлогдоно.

20 дугаар зууны сүүл үеэс эхлэн улс төрийн болон

сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг хянах, сонгуулийн маргаан шийдвэрлэх чиг үүргийг гүйцэтгэх зэрэг сонгуулийн үйл явцын тодорхой үйл ажиллагааг зохицуулах эрх хэмжээ бүхий сонгуулийн удирдлагын бие даасан байгууллагуудыг байгуулах болсон. Ихэвчлэн эрх зүйн байдлыг нь тухайн улсын Үндсэн хуульд тусгаж, байгууллагын хувьд хараат бус байдлыг хангаж, татан буулгах боломжийг хязгаарладаг.¹⁷ Өөрөөр хэлбэл, сонгуулийн удирдлагын байгууллагын бүтцийн бие даасан байдлыг улс орнууд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоороо тодорхойлдог байна.

Сонгуулийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, төсөв болон хүний нөөцтэй холбоотой асуудлууд нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас шууд хамааралтай бол үйл ажиллагааны бие даасан байдал нь алдагдах эрсдэл үүсгэдэг.¹⁸ Үйл ажиллагаагаа бие дааж, хараат бусаар явуулах эрх зүйн орчин бүрдсэн эсэх нь үйл ажиллагааны бие даасан байдлыг илтгэх гол шалгуур болдог. Сонгуулийн удирдлагын байгууллагын шийдвэр гаргах үйл явц нь улс төрийн нөлөөнд автсан, түүнчлэн шийдвэр гаргах бүтцэд нь аль нэг улс төрийн намын төлөөлөл давамгайлсан байх зэрэг шалтгааны улмаас сонгуулийн удирдлагын байгууллага нь бүтцийн хувьд бие даасан хэдий ч үйл ажиллагааны хувьд бие даасан байдал нь хангагдахгүй байх нөхцөл үүсдэг.¹⁹

Сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгуулийг хараат бусаар зохион байгуулахаас гадна сонгогчдын боловсролд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулах үндсэн чиг үүрэгтэй байдаг. Энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аливаа улс төрийн нам эсвэл, нэр дэвшигчдээс хараат бусаар зөвхөн сонгогчдод сонгуулийн боловсрол олгох зорилгоор явуулдаг. Дэлхийн бусад улс орны сонгуулийн удирдлагын байгууллагууд дэргэдээ дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх бие даасан нэгж ажиллуулдаг. Жишээ нь, БНСУ-ын Үндэсний сонгуулийн комисс нь дэргэдээ ардчилал, сонгуулийн боловсрол олгох чиг үүрэг бүхий бие даасан нэгж ажиллуулж байна. Мөн БНЭУ, ӨАБНУ, Филиппин, Индонез зэрэг улсыг дурдаж болох юм. Эндээс үзвэл сонгогч зөвхөн өөрийн итгэл үнэмшлээрээ, хараат бус, чөлөөт сонголтоо хийсэн сонгуулийн үр дүнг баталгаажуулж, хуульд заасны дагуу нэгтгэн сонгуулийн үр дүнг гаргадаг сонгуулийн удирдлагын байгууллага энэхүү чиг үүргээ хэнээс ч хараат бусаар зохион байгуулах, сонгогчдод сонгуулийн болон ардчиллын боловсрол олгох эрх зүйн болон бусад нөхцөл бүрдсэн эсэх нь үйл ажиллагааны бие даасан байдал гэх ойлголтод хамаарч байна.

Санхүүгийн бие даасан байдал нь аливаа байгууллагын эдийн засгийн баталгаа нь бусад эрх мэдлийн байгууллагаас хараат бусаар ажиллах нэг нөхцөл болдог. Өөрөөр хэлбэл төсвийн бие даасан байдал нь чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэр, нөөцөөр хангах, түүнийг төлөвлөх, зарцуулах зэрэг үйл ажиллагааны хараат

13 Ernst-Wolfgang Böckenförde, (2017). "The Concept of the Political: A Key to Understanding Carl Schmitt's Constitutional Theory," in constitutional and political theory: selected writings (Mirjam Künkler & Tine Stein eds., Oxford University Press, Pp 191

14 Мөнхсайхан, О. (2022). Ерөнхийлөгч: Эрх зүйн байдал, бүрэн эрх. УБ., 145 дугаар тал.

15 CUTS Centre for Competition, (2006). Investment & Economic Regulation. Institutional Independence in India. pp 2

16 Cheeseman, N., Elklit, J., Westminster foundation for Democracy "Understanding and Assessing Electoral Commission Independence: a New Framework", London 2020, P. 15.

17 IDEA, (2021). "Independence in Electoral Management", Sweden, P.10.

18 Мөн тэнд

19 International Institute for Democracy and Electoral Assistance (2014) Election Management design: handbook. revised, p.6

бус байдлаас шууд хамаарна.²⁰ Төсвийн бие даасан байдал нь объектив хүчин зүйлд хамаардаг. Үүнд төсвийн хувьд бие даасан байх эрх зүйн орчин бүрдсэн эсэх, бие даасан байдал бүрэн бодитой баталгаажсан эсэх зэрэг нөхцөл байдал нөлөөлдөг.²¹ Санхүүжилтийн хэмжээ нь бие даасан байдлаас илүүтэйгээр чадавхтай холбоотой асуудал хэдий ч санхүүжилтийг цагт нь олгох, төсөвт тусгагдсан мөнгөө юунд зарцуулахаа сонгуулийн удирдлагын байгууллага зөвхөн өөрөө хуулийн дагуу бие даан шийдвэрлэдэг, төлөвлөдөг байх нь бие даасан байдлын нэг чухал шалгуур юм.

Мөн хараат бус байдлыг институтийн (institutional independence) болон хувийн (personal impartiality) гэсэн хоёр түвшинд хувааж авч үздэг. Институтийн бие даасан байдал хангагдах нь дээрх дурдсанаар эрх зүйн байдлыг Үндсэн хуулиар тодорхойлсон уу, эсхүл ердийн хуулиар тодорхойлсон уу гэдэг нь тодорхой нэг шалгуурт хамаарч байхад хувийн хараат бус байдлыг хамгаалах нь гишүүний үйл ажиллагааны баталгааг эрх зүйн орчноор хангаж өгсөн байдал, мөн тухайн гишүүний өөрийн зан байдал, ажлын туршлага, хувь хүний ёс суртахуун зэргээс хамааралтай.²² Гишүүний хараат бус байдал, түүний баталгаа нь институтийн бие даасан байдлын суурь шалгуурын нэг болдог. Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүдийн тоо, томилгоог санал болгох субъект, түүнд ногдох мандатын тоо, сонгон шалгаруулах журам, гишүүнд тавигдах шаардлага, бүрэн эрхийн хугацаа, үйл ажиллагааны баталгаа зэргийг улс орон бүр харилцан адилгүй тогтоосон байдаг.

Дэлхийн ихэнх ардчилсан улсад сонгуулийг ил тод, шударга зохион байгуулж, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг хуульд нийцүүлэн удирдаж, хянах зорилгоор байнгын ажиллагаатай сонгуулийн удирдлагын байгууллага ажилладаг. Парламентыг чөлөөт, шударга сонгуулиар ард түмэн өөрсдийн төлөөлөөрөө бүрдүүлэх нь ардчиллын суурь зарчим тул энэхүү сонгуулийг зохион байгуулдаг байгууллага нь бие даасан, хараат бус байх зайлшгүй шаардлагатай юм.

Дэлхийн улс орнуудын сонгуулийн удирдлагын байгууллагууд бүтэц, зохион байгуулалтын хувьд олон янз байх ч сонгуулийн удирдлагын бие даасан, засгийн газрын болон холимог гэсэн гурван загвар байдаг.²³

Нэгд, сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан загварт хамаардаг сонгуулийн удирдлагын байгууллага нь аль ч эрх мэдлээс хараат бус, институтийн хувьд бие даасан байх бөгөөд засгийн газарт ажлаа тайлагнах үүрэг хүлээдэггүй. Ийм байгууллага нь өөрийн төсөвтэй, санхүүгийн хувьд бие

даасан байна. Мөн сонгуулийн удирдлагын байгууллагыг Засгийн газраас хараат бусаар байгуулдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, түүний бүрэлдэхүүнд засгийн газрын гишүүн багтдаггүйн зэрэгцээ үйл ажиллагаанд нь засгийн газрын байгууллага хөндлөнгөөс оролцдоггүй. Мөн бие даасан байдлыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тодорхойлж, бие даасан байх эрх зүйн орчныг хуульчилсан байдаг. Армени, Босни-Герцеговина, Канад, Коста Рика, Эстони, Гүрж, Энэтхэг, Индонези, Нигери, Польш, Өмнөд Африк, Тайланд, Уругвай, Монгол, Солонгос энэ загварыг хэрэглэдэг.²⁴

Хоёрт, сонгуулийн удирдлагын байгууллагын засгийн газрын загвар нь сонгуулийн үйл явцыг төрийн яам болон орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан удирдан зохион байгуулдаг онцлогтой. Тодруулбал, сонгуулийн хороодыг улсын хэмжээнд төрийн сайд эсхүл тусгайлсан албан тушаалтан удирдаж, төсөв нь засгийн газрын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг. Энэ загварыг ашигладаг улсад Дани, Сингапур, Швейцарь, Их Британи, АНУ орно. Швед, Швейцарь, Их Британи, АНУ-д сонгуулийн зохион байгуулалтыг орон нутгийн эрх баригчид хэрэгжүүлдэг.²⁵

Гуравт, сонгуулийн удирдлагын байгууллагын холимог загвар нь ихэвчлэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй буюу давхар бүтцийг агуулдаг. Тухайлбал, нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагааг нь гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус, байнгын ажиллагаатай сонгуулийн төв байгууллага хэрэгжүүлдэг бол сонгуулийн тойрог, нутаг дэвсгэрийн хэмжээнд сонгуулийг зохион байгуулах чиг үүрэг бүхий доод шатны сонгуулийн байгууллагуудыг Засгийн газраас эсхүл тухайн орон нутгийн удирдлагаас байгуулдаг. Холимог загварыг Франц, Япон, Испани, хуучин Францын колони байсан олон оронд, ялангуяа Баруун Африкт, тухайлбал Мали, Сенегалд ашигладаг.²⁶ Доод шатны сонгуулийн байгууллагын бие даасан эрх мэдэл, чиг үүрэг нь энэ загварыг ашигладаг улс орнуудад харилцан адилгүй ч зарим тохиолдолд эрх, үүрэг, хяналтын тогтолцоо нь тийм ч тодорхой бус байдаг. Үүнээс үүдэлтэйгээр сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны нэгдмэл, хараат бус удирдлага алдагдах, сонгуулийн үр дүнг баталгаажуулах үйл ажиллагаанд субъектив байдлаар нөлөөлөх, үүнээс шалтгаалан сонгуулийн хууль ёсны байдлын талаар маргаан гарах өндөр эрсдэл дагуулдаг.²⁷ Сонгуулийн удирдлагын байгууллагын хувьд холимог загварт хамаарах боловч бие даасан бүрэлдэхүүнтэй сонгуулийн удирдлагын байгууллагын эрх мэдэл нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Гэвч ерөнхий нийтлэг шинжээр нь авч үзвэл бүрэн бие даасан сонгуулийн удирдлагын байгууллагатай адил мэт боловч сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг орон нутгийн түвшинд нэгдсэн удирдлагаар хангах доод шатны сонгуулийн байгууллагууд нь төсөв, санхүү, бүрэлдэхүүний

20 Cheeseman, N., Elklit, J., Westminster Foundation for Democracy. (2020). Understanding and Assessing Electoral Commission Independence: a New Framework, London, P. 12.

21 Consultative Council of European Judges. (2015) The Independence of the Judiciary and its Relations with the Other powers in a Modern Democratic State, Strasbourg,

22 International Institute for Democracy and Electoral Assistance handbook, (2014), revised, p.12

23 International Institute for Democracy and Electoral Assistance (2014) Election Management design: handbook. revised, p.6

24 Мөн тэнд

25 Мөн тэнд

26 Мөн тэнд

27 International Institute for Democracy and Electoral Assistance (2014) Election Management design: handbook. revised, p.8

хувьд засгийн газраас хараат бус байгаа шинжээрээ ялгаатай юм.²⁸

Монгол Улс 1992 онд баталсан Үндсэн хуулиараа эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон тунхаглан зарлаж, Монгол Улсын иргэд бүх нийтээрээ, сайн дурын үндсэн дээр, яс үндэс, угсаа гарал, шашин шүтлэг, нас хүйс, үзэл бодол үл харгалзан, чөлөөтэй, шууд, нууц санал хураалтаар төрийн эрх барих дээд байгууллагаа сонгох, түүнд сонгогдох эрхийг хуульчлан баталгаажуулж, сонгуулийг зохион байгуулж явуулах Сонгуулийн төв байгууллагын эрх зүйн үндэс суурийг тодорхойлсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлд Сонгуулийн төв байгууллага, түүний гаргах шийдвэрийн талаар тодорхойлон хуульчилсан нь үзэл баримтлалын хувьд, нэгдүгээрт: сонгуулийн төв байгууллага нь ард нийтийн санал асуулга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал түүний гишүүнийг сонгох сонгуулиудыг зохион байгуулж явуулах үндсэн байгууллага нь сонгуулийн төв байгууллага болохыг тодорхойлж; хоёрдугаарт: сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан байна.²⁹

Эндээс үзвэл, Монгол Улсын Үндсэн хуульд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан нь үзэл баримтлалын хувьд түүний бие даасан, хараат бус байх эрх зүйн байдлыг Үндсэн хуулиар шууд бус байдлаар тодорхойлжээ.

Улсын бага хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороог Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд эрхлэн явуулах үүрэгтэй байнгын ажиллагаатай байгууллага байхаар зааж, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг нь энэхүү хуулиар тодорхойлсон байна. Улмаар 1992 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын Бага Хурлын 18 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороог 15 гишүүнтэйгээр байгуулж, мөн оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг тус Хороонд зөвшөөрсөн байдаг.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 1992 оны хуульд "Сонгуулийн ерөнхий хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна. Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг 5 жилийн хугацаагаар Улсын Их Хурлаас томилно. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд орон тооны бус байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга нь ажлын шаардлагыг харгалзан бүтэн буюу хагас /хавсарсан/ орон тоогоор ажиллана. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Нарийн бичгийн дарга, гишүүн нь Улсын Их

Хурлын гишүүнд нэр дэвшигч байж болохгүй. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа хийхийг хориглоно, бүрэн эрхийнхээ асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэж тогтоол гаргана." гэх зэргээр Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн байдлыг анхлан хуульчилжээ.

Мөн Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулахдаа сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, түүнийг нэг мөр сахин биелүүлэх явдлыг хангах, сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах, сонгууль бэлтгэн явуулах асуудлаар төрийн зохих байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, сонгуулийн тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргаан бүхий бусад өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх зэрэг бүрэн эрхтэй болохыг хуульчилсан. Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд зардлын хэмжээг Улсын Их Хурал тогтоохоор тус тус хуульчилж сонгуулийн байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагааны баталгааг тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурал 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан үзэл санаанд нийцүүлэн Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг баталж түүний эрх зүйн байдлыг тодорхойлж, тусдаа хуулиар зохицуулах болсон. Уг хуульд Сонгуулийн ерөнхий хороо нь үйл ажиллагаагаа бие дааж, хараат бус байдлаар явуулах бөгөөд Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага байхаар хуульчилсан. Мөн тус Хороо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэгтэй байхаар хуульчилсан байна. Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны, долоо нь орон тооны бус байна.

Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилохоор хуульчилсан. Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нэмэлт оруулж Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсгол хийхээр нэмж зохицуулсан.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг анх 2005 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай хамт өргөн мэдүүлсэн байдаг. Улмаар 2005 оны 7 дугаар сарын 7 өдөр хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы

28 Мөн тэнд

29 Содномцэрэн, Ч. (2019). "Шинэ тулгар ардчилсан орнууд дахь сонгуулийн сорилтууд: Ази, Арабын орнуудын туршлагаас хуваалцах нь" сэдэвт олон улсын бага хуралд танилцуулсан илтгэл.

нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.³⁰ Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт өргөн мэдүүлснээс шалтгаалан байнгын хорооны хуралдаан болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдлаас илүүтэйгээр сонгуулийн тогтолцоотой холбоотой асуудлаар гишүүд уг хэлж, санал, шүүмжлэлээ дэвшүүлсэн талаарх мэдээлэл их уг хуулийн хувийн хэрэгт их байна. Харин сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний тоо, тавигдах шаардлага, томилгоог санал болгох субъектийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргасан талаарх гишүүдийн томьёолсон санал байх боловч ямар шалтгаанаар уг саналыг гаргасан талаарх мэдээлэл тун хомс байна. 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан "Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн төслийг тусгайлан боловсруулав. Сонгуулийн ерөнхий хороог бие даасан, хараат бус, мэргэжлийн байгууллага байхаар тогтоож, түүний эрх, үүргийг өргөтгөх чиглэлээр тухайлбал Сонгуулийн тухай хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах, нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуульд зориулсан хөрөнгийн хэмжээг нийтэд мэдээлэх, их хэмжээний мөнгө хандивлагчийг нийтэд зарлах, нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын сангийн тайланг хянан хэлэлцэх, дүнг нийтэд мэдээлэх зэрэг бүрэн эрх эдлэхээр хуульчлан зааж өгсөн болно" гэж хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулж байжээ.³¹

Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд 2006 онд батлагдсанаас хойш 2007, 2015, 2021, 2023 онд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь тухайн цаг үед мөрдөгдөж байсан сонгуулийн хууль тогтоомжийн нэр томьёоны өөрчлөлтөд үндэслэн хийгджээ. Өөрөөр хэлбэл, 2021 оны нэмэлт өөрчлөлтөөр Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч нь нэр дэвшигчийн сонсгол хийх тухай шинэчлэл орсныг эс тооцвол сонгуулийн төв байгууллагын хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх эрх зүйн хөгжлийн чиг хандлагатай нэмэлт, өөрчлөлт ороогүй юм. Харин 2023 онд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор намд санхүүжилт олгох, түүнд хяналт тавих, намын нээлттэй мэдээллийг тогтмол ил тод байлгах зэрэг чиг үүргийг Сонгуулийн ерөнхий хороо хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тодорхой чиг үүргийг нэмж хуульчилсан.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлээр **Хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журмын эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон байдаг.** Тухайлбал, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т зааснаар Хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилох бөгөөд Хорооны дарга, нарийн бичгийн дарга нь орон тооны байна. Мөн Хорооны гишүүн нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч байхыг хориглохоор хуульчилсан.

Харин хорооны гишүүний бүрэн эрхийн хугацааны тухайд зургаан жил байхаар хуульчилсан боловч түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар бүрэн эрх нь эхэлж, дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болох зохицуулалттай.

Бие даасан байгууллагын гишүүний үйл ажиллагааны баталгаа талаас нь тодорхой зохицуулалтуудыг мөн хуульчилсан байдаг. Тухайлбал, дээр дурдсан үндэслэлээс өөр үндэслэлээр Хорооны гишүүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг хориглоно гэж хуульчилжээ.

Эндээс үзвэл, Монгол Улсын Сонгуулийн төв байгууллага нь институтын хувьд сонгуулийн удирдлагын бие даасан байгууллагад хамаарахаар Монгол Улсын Үндсэн хуулийн шууд бус зохицуулалтаар болон салбарын эрх зүйн орчныг хуульчилсан байна. Гэвч хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэхэд сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, үйл ажиллагааны үндсэн зарчим, чиг үүргийг нарийвчлан тодорхойлох нь дээр дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэх үндэслэл болох юм.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

30 Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн хувийн хэрэг. Улсын Их Хурлын тамгын газар. 2006 он

31 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл



ЖО ЖИНЖҮ: Сонгуулийн удирдлагын байгууллагын загвар

Илтгэлийнхээ өмнө Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо /A-WEB/-ы чиг үүргийг товч танилцуулъя. Сонгуулийн үндсэн асуудлыг тодорхойлох, зохицуулах чиг үүрэг гүйцэтгэдэг. Сонгогчдын бүртгэл, тойрог тодорхойлох, процессын ил тод, шударга байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулдаг. Сонгуулийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс ажиглалт, мониторинг зохион байгуулдаг. Түүнчлэн сонгуулийн кампанит ажлын санхүүжилт, үйл ажиллагаа, зохион байгуулалт зэрэгт хөндлөнгийн ажиглалт тавьдаг.

- » Нэгдүгээрт: Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх,
- » Сонгуулийн тойргийг тодорхойлох,
- » Сонгогчдын санал авах өдрийн зохион байгуулалтыг ажиглаж, мониторинг хийдэг.

ХУРААНГУЙ

Энэхүү Эрдэм шинжилгээний бага хурал орчин цагийн болон ирээдүйн сонгуулийн төв байгууллагын хууль эрх зүйн зохицуулалтыг судлах чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Энэ удаагийн хуралд хэлэлцүүлэх "Сонгуулийн удирдлагын байгууллагын загвар" сэдэвт илтгэл маань

1. Тодорхойлолт
2. Цар хүрээ
3. Үүрэг, хариуцлагын ялгаа гэсэн агуулгын хүрээнд байх юм.

СОНГУУЛИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАГВАР

Улс төр болон засаг захиргааны тогтолцоонд тулгуурласан сонгуулийн удирдлагын байгууллагын 3 загвар байна.

1.Хараат бус загвар

Үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эрх мэдлийг олгодог. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүдээс бүрэн хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг. Эстони зэрэг улсын сонгуулийн удирдлагын байгууллага энэ загвараар ажилладаг. Бүрэн хэмжээнд бие даасан байдлаар сонгууль зохион байгуулдаг энэхүү загвар институтийн хувьд хүчтэй бөгөөд хууль эрх зүйн хараат бус байдал нь бүрэн хангагдсан. Сул тал гэвэл маш өндөр өртөгтэй байдаг.

2.Засгийн газрын загвар

Засгийн газар нь маш том үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газар, яамд болон орон нутгийн удирдлагууд сонгуулийн зохион байгуулалтыг хариуцдаг. Энэ загвар нь Засгийн газрын институтээс шууд хамааралтай бөгөөд тэдний нөлөө орох эрсдэл ажиглагддаг.

3.Холимог загвар

Сонгуулийн удирдлагын холимог тогтолцоо нь бодлого, гүйцэтгэл гэсэн хоёр бүрэлдэхүүнээс бүрддэг. Сонгуулийн ерөнхий хороо, иргэний бүртгэлийн байгууллага, сонгуулийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулдаг 3 байгууллага хамтран оролцдог. Олон бүтэц, байгууллага оролцдог учраас хууль эрх зүйн зохицуулалт болон журам, дүрэм маш тодорхой байх шаардлагатай байдаг.

Сонгуулийн зохион байгуулалт, зохицуулалтад зөвхөн нэг загвар зөв гэж дүгнэхэд төвөгтэй. Харин сонгуулийн удирдлагын байгууллагын баримтлах үндсэн зарчим нь үр дүнтэй бөгөөд найдвартай байдлыг хангах 5 зарчмыг гаргасан. Үүнд:

1. Бие даасан байдал
2. Хараат бус байдал
3. Ил тод байдал
4. Үр дүнтэй ажиллах
5. Сонгогчдод чиглэсэн үйлчилгээнд төвлөрөх.

Ирээдүйд буюу сонгуулийн удирдлагын байгууллагын загварт нөлөөлөх зүйлсийг дараах байдлаар тодорхойлж байна.

- » Цахим санал хураалтыг хэрэгжүүлэх
- » Хуурамч мэдээлэлтэй тэмцэх
- » Хүртээмжтэй байдлыг хангахад олон улс чиглэж ажиллаж байна.

Эдгээр 3 үндсэн асуудал ирээдүйд сонгуулийн менежментэд нөлөөлнө хэмээн дүгнэж байна.

Эцэст нь дүгнэхэд, Үндсэн хуульт ардчиллыг хөгжүүлэх, Үндсэн хуульт төрийг хангахад сонгуулийн удирдлагын байгууллага маш чухал үүрэг гүйцэтгэж байна.



ЛИ ИННА КИМ: Сонгуулийн удирдлагын байгууллагад тулгарч буй сорилт, шийдвэрлэх арга зам

ХУРААНГУЙ

Сонгуулийн удирдлагын байгууллагын загваруудтай холбоотой хэд, хэдэн сорилт гарч байна. Улс орнуудын туршлагаас харахад тулгарч байгаа сорилт, туршлага нь төстэй байгаа учраас нийтлэг байдлаар илтгэнэ.

СОРИЛТ, ТУРШЛАГА

Сорилтын шийдвэрлэх боломж бололцоо ч түгээмэл. Тухайлбал, техник технологитой холбоотой сорилтыг шийдвэрлэх боломж гарч байна. Хиймэл оюун ухааны хөгжилтэй холбоотой сонгуулийн үеийн хуурамч, худал мэдээлэлтэй тэмцэхтэй зэрэгцээд сонгуулийн процесс, үйл ажиллагааг шинэчлэх нь зайлшгүй чухал болоод байна.

Техник, технологитой холбоотой сорилт, боломжуудыг онцолъё. Тухайлбал, системийн алдаа, кибер аюулгүй байдалтай холбоотой эрсдэл болон өндөр үнэ өртөг, ашиглалтын зардал их, байнгын сургалт шаардлагатай гэх мэт сорилтууд гарч байгаа. Техник, технологитой холбоотой ямар шийдэл гарч байна, хууль эрх зүйн зохицуулалт ямар байх, олон нийтийн итгэл үнэмшил хангагдаж байна уу гэдэг нь чухал юм.

Филлипин, Сальвадор, Эквадор улсуудын туршлагыг танилцуулъя. Эдгээр улс нь гадаад улсад байгаа иргэдийнхээ саналыг онлайнгаар авах тогтолцоог нэвтрүүлсэн. Сонгуулийн санал хураалтын үйл явцыг бага өртөгтэй, үр дүнтэй байлгахын тулд онлайн санал хураалтыг ашиглаж байна. Сальвадор улс Ерөнхийлөгчийн 2024 оны ээлжит сонгуульд онлайн санал хураалтыг ашигласнаар гадаад улс дахь сонгогчдын идэвх 95.6 хувь болж өссөн. Зардлын хувьд тооцоход өмнөх сонгуулиар гадаад улс дахь иргэдийнхээ саналыг авахад 799 мянган ам.доллар зарцуулж байсан бол онлайнгаар санал авснаар 32 мянган ам.доллар хүртэл

бууруулж чадсан байна. Түүнчлэн олон нийтийн итгэлийг ч нэмэгдүүлсэн тухай судалгааны дүн гарсан. Эквадор улсын тухайд гадаад улсад амьдарч байгаа иргэдийн 1/3 сонгуульд оролцож чаддаггүйгээс олон нийтийн итгэл буурч байсан. Үүнтэй холбоотойгоор тус улс 2025 оны ээлжит сонгуулиар онлайнгаар санал авахаар төлөвлөж байгаа. Эдгээр жишээтэй холбоотойгоор гадаад улсад амьдарч байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ сонгуульд оролцуулахад техник, технологийн дэвшлийг ашиглах нь үр дүнтэй нь харагдаж байна. Гэхдээ техник, технологитой холбоотой зохицуулалт маш чухал.

Нөгөө талаас хиймэл оюун ухаантай холбоотой маш их сорилт гарч байна. 2024 оны сонгуулийн үеэр хиймэл оюун ухаантай холбоотой хуурамч мэдээллийг хязгаарлах, тэмцэх асуудлыг чухалчилж авч үзсэн. Европт санал хураалт болохоос 90 хоногийн өмнө хиймэл оюун ухаантай холбоотой мэдээлэл түгээхийг хориглох зэрэг практикийг ашигласан. Тодруулбал, Дижитал үйлчилгээний тухай хууль баталж хэрэгжүүлсэн. 2024 онд хийсэн судалгаагаар хиймэл оюунаар үүсгэсэн мэдээлэл сонгогчдын саналд нөлөөлж байна гэдэг дүгнэлт гарсан. Үүнтэй холбоотой хууль эрх зүйн хувьд ямар хамгаалалт үүсгэх вэ гэдэг асуудал яригдсан. Нийгэм, улс төрийн тогтворгүй байдалд өртсөн улс орнуудын нөхцөл байдлыг харахад хиймэл оюун ухаан, сонгуулийн үеийн маргаантай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт чухал гэж дүгнэсэн.





Үндсэн хуульт ардчиллыг хамгаалахад
сонгуулийн төв байгууллагын гүйцэтгэх үүрэг
Олон улсын эрх зүйн шинжлэх ухааны бага хурал

“ELECTORAL MANAGEMENT BODY DESIGN”
Сонгуулийн удирдлагын байгууллагын загвар

Ms.Taerjung Lee
Deputy Director, Communications Team, Secretariat Office, Association of the World Election Bodies

ЛИ ТЭРИОН: Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо /A-WEB/-ны үүрэг оролцоо, дэмжлэг

Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо /A-WEB/ сонгуулийн удирдлагын байгууллагуудыг хэрхэн дэмжиж ажилладгийг танилцуулъя. Манай байгууллага 2013 онд байгуулагдсан, БНСУ-д төв нь байрладаг. Улс орнуудын сонгуулийн удирдлагын байгууллагад тулгарч байгаа бэрхшээл, сорилтыг шийдвэрлэхэд олон улс хамтарч ажиллахыг зохицуулах зорилгоор байгуулагдсан бөгөөд Африк, Европ, Ази, Америк тивүүдэд үйл ажиллагаа явуулж байна. Улс орнууд шилдэг туршлагаа хуваалцах зорилгоор 109 оны 119 гишүүн хамтарч ажилладаг. Шударга, чөлөөтэй, хүртээмжтэй сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах, менежментээ хангахад шилдэг туршлагаа хуваалцах, сорилт бэрхшээлээ шийдвэрлэх арга зам олоход дэмжлэг үзүүлдэг. Үндсэн хуульт ардчиллыг хөгжүүлэх, бэхжүүлэх зорилготой ардчиллын үнэт зүйлс, соёлд тулгуурлан ажилладаг.

Сонгуулийн удирдлагын байгууллагын хараат бус, бие даасан байдал, дотоод хүчин чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

МЭДЛЭГ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ- Онлайн платформ үүсгээд гишүүн орнуудаасаа мэдээллийн сан бүрдүүлдэг. Шинжлэх ухаанч, дата мэдээлэлд тулгуурласан, судалгаанд ашиглаж болохуйц мэдээллээр сангаа бүрдүүлж байна.


Сонгуулийн тогтолцоо, менежмент зэрэг мэдээлэлд түлхүү анхаардаг. Өөрөөр хэлбэл, дэлхийн хэмжээний дата мэдээлэл цуглуулж, судалгаа хийдэг. Хэд, хэдэн үзүүлэлтээр гишүүн улсуудаас мэдээлэл цуглуулан сонгуулийн удирдлагын байгууллагын чиг үүрэг, хууль эрх зүйн үндэс зэрэг үзүүлэлтээр дүгнэсэн. Судалгаагаар сонгуулийн удирдлагын байгууллагын хамгийн чухал чиг үүрэг бол сонгуулийн менежмент гэдэг дүгнэлт гарсан. Дарга томилох болон сонгох үйл явц, гадаад улсад байгаа сонгогчдынхоо саналыг хэрхэн авдгийн мөн анхаарч авч үздэг.

Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо (A-WEB)-ы гишүүн орнуудын мэдээллээ солилцдог өөр нэг платформ бол сар тутам гардаг сонин. Улс орнуудаасаа чухал, ач холбогдол бүхий үйл явдлын мэдээллээр сониноо бэлтгэдэг.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР- Нарийн бичгийн дарга нарын газар байгуулагдсанаар 1200 гаруй сонгуулийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулсан. Гишүүн улсуудаас сургалтын хэрэгцээ шаардлагын судалгаа авсны үндсэн дээр хөтөлбөрөө боловсруулж, хурал чуулганыхаа сэдвийг тодорхойлдог.

Энэ мэтчилэн гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлэх бүхий л чиглэлээр ажиллаж байна.





ШЭБУРИ ВОЛТЭР РАМАБЭЛЭ: “ӨАБНУ-ын сонгуулийн комиссын эрх зүйн байдал, чиг үүрэг”

ХУРААНГУЙ

Энэ удаагийн илтгэлээ дараах дөрвөн асуудлын хүрээнд бэлтгэлээ.

1. Улсын нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин
2. Сонгуулийн комиссын гишүүдийн томилгоо,
3. Сонгуулийн комиссын гишүүдийг албан тушаалаас чөлөөлөх процесс
4. Сонгуулийн комиссын чадамж, Үндсэн хуулийн бүрэн эрх

Улс орнууд сонгуулийн удирдлагын институтын загвараа тодорхойлохдоо өөрийн улсынхаа нөхцөл байдлыг маш их харгалзан үздэг. Манай улс ч гэсэн ийм байдлаар загвараа тодорхойлсон.

Гадуурхалт, дарангуйлал, үл итгэлцэл бүхий манай улсын хүнд, хэцүү түүх “Дахиж л ийм байдалд орохгүй шүү” гэсэн айдас, болгоомжлолын үндсэн дээр сонгуулийн удирдлагын байгууллагын загвараа тодорхойлсон. Үүнийгээ ч Үндсэн хуульд маш сайн зааж өгсөн.

Үндсэн хуульд ардчиллыг бэхжүүлэх үүрэг бүхий байгууллагуудын тодорхойлсны нэг нь Сонгуулийн комисс юм. Үндсэн хуулийн байгууллага гэдэг утгаараа ардчиллаа хамгаалдаг гэж өөрсдийгөө үздэг. Эдгээр байгууллага бүгд бие даасан, хараат бус ажиллахыг Үндсэн хуульдаа маш тодорхой заасан. Хэн нэгэнд тал засахгүй, ямар нэгэн айдасгүйгээр чиг үүргээ гүйцэтгэдэг. Ямар ч албан тушаалтан, эрх мэдэлтэн Үндсэн хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд саад учруулах эрхгүй, төрийн бусад байгууллага хамгаалах үүрэгтэй байдаг.

Дээд шүүхийн эцсийн шийдвэрт Сонгуулийн комиссын бие даасан байдал нь

1. Санхүүгийн бие даасан байдал
2. Үйл ажиллагааны бие даасан байдал гэдэг хоёр янзаар илэрдэг гэж заасан.

Санхүүгийн бие даасан байдлын тухайд “Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих хөрөнгийг хуваарилуулах боломжтой байх ёстой”;

Үйл ажиллагааны бие даасан байдлын тухайд “Хорооны гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой асуудлыг Комисс өөрийнхөө л хяналтад байлгана” гэж Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт заасан.

Үндсэн хуулиар манай байгууллагын бие даасан, хараат бус байдлыг тунхагласан тул комиссын гишүүдийг хувь хүний хувьд ч чадвартай, бие даасан, хараат бус байхыг шаарддаг. Комиссын гишүүдийг томилох асуудлыг Үндсэн хууль болон комиссын хуульдаа заасан. Комисс таван гишүүнтэй бөгөөд 7 жилийн хугацаатайгаар томилох ба нэг нь заавал шүүгч байхыг шаарддаг. Гурван гишүүн байнгын албан тушаалтай. Гишүүний бүрэн эрхийг зөвхөн нэг удаа сунгах боломжтой. Сонгуулийн хорооны гишүүнийг томилох үйл явц олон нийтэд нээлттэй явагддаг. Ерөнхий шүүгчээр ахлуулсан баг нэр дэвшигчдийг сонгон шалгаруулж, ярилцлагад оруулсны дараа Үндэсний Ассамблейд нэр дэвшигчдийн танилцуулгыг явуулдаг. Үндэсний Ассамблейн бүх намын гишүүдээс бүрдсэн хороо зөвлөмж гаргаснаар Ерөнхий хуралдаанд танилцуулж, олонхын саналаар нэр дэвшүүлж, Ерөнхийлөгчид санал болгоно. Сонгуулийн комиссын гишүүнийг Үндэсний ассамблей санал болгосны үндсэн дээр Ерөнхийлөгч томилох хуультай. Өмнөд Африкийн иргэн байхаас гадна тухайн албан тушаалыг хашихад зохистой байх ёстойг хуульчилсан.

Комиссын гишүүнийг зөвхөн дараах тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлж болдог. Мэдээж нэлээн үйл явдал өрнөж Үндэсний Ассамблей үндэслэлээ нарийн

тодорхойлсны дараа чөлөөлдөг. Үндэсний Ассабмлейн процесс эхэлсний дараа л Ерөнхийлөгч комиссын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлж болно.


Сонгуулийн комиссын үндсэн чиг үүрэг, зорилго нь Үндсэн хуульд зааснаар үндэсний, мужийн, хотын, хууль тогтоох байгууллагын сонгуулийг чөлөөт, шударгаар зохион байгуулах. Сонгуулийн комиссын тухай хуулийн 5 дугаар хэсэгт байгууллагын чиг үүргийг аливаа сонгуулийг удирдан зохион байгуулах, түүний дотор нэр дэвшигчдийг нэр дэвшүүлэх, албан тушаалд нэр дэвших шалгуурыг хангасан эсэхийг хянах, сонгуулийг чөлөөтэй, шударга байдлаар явуулахыг баталгаажуулах, чөлөөт шударга сонгууль явуулах нөхцөлийг дэмжих, сонгогчдод боловсрол олгох, сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах, хөтлөх, улс төрийн намуудын бүртгэлийг хөтлөх, мужууд дахь салбаруудтай хамтарч ажиллах зэргээр заасан байдаг. Мөн сонгуулийн процессын судалгаа хийх, үр дүнг түгээн дэлгэрүүлэх, сонгуулийн технологийг хөгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хянаж, зөвлөмж гаргах, сонгогчдын боловсролыг дэмжих үүрэгтэй. Зорилгодоо хүрэхийн тулд иргэд, иргэний

нийгмийн байгууллага, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, хоорондын хамтын ажиллагааг дэмжих болон бүх талд бүрэн нээлттэй байхыг зорьдог.

Сонгуулийн комисс чиг үүргээ хэрэгжүүлэхдээ сонгуулийн удирдлагын хороо, эрсдэлийн хороо, санхүүгийн хороо, хүний нөөцийн хороо, судалгаа, мэдээллийн хороо зэрэг дэд хороод ажиллуулдаг. Гишүүд маань эдгээр хороодод хамаардаг.

Улс орнууд хараат бус, бие даасан сонгуулийн загварыг сонгох уу холимог байх уу гэдэг нь тухайн улсын онцлогоос хамаардаг. Манай Өмнөд Африк маш их үнээр олсон ардчиллаа хамгаалахын тулд хараат бус, бие даасан сонгуулийн байгууллагын загвар сонгосон гэдгийг дахин хэлмээр байна. Маргаан зөрчлийг Үндсэн хуульдаа тулгуурлаж шийдвэрлэдэг, хорооны шийдвэрийг Үндсэн хуулийн цэц л хянадаг. Тиймээс бие даасан, хараат бусаар ажиллаж чадвал төдийлөн асуудал гарахгүй. Бидний бүх үйлдэл хуульд л зохицуулагдаж байдаг.





КИМ СЭ ХҮН: “БНСУ-ын үндэсний сонгуулийн комиссын эрх зүйн байдал, чиг үүрэг”

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний сонгуулийн комисс сонгууль зохион байгуулахаас гадна сонгогчдод сонгуулийн боловсрол чиглэлээр ажиллаж байна. Сонгуулийн комисс БНСУ дахь ардчилсан тогтолцооны баталгаа болж өгдөг.

Үндсэн Хуулийн 114 дүгээр зүйлд Үндэсний сонгуулийн комиссын бүрэн эрхийг заасан.

114 ДҮГЭЭР ЗҮЙЛ:

(1) Сонгууль, үндэсний санал асуулгын шударга удирдлагыг хангах, түүнчлэн улс төрийн намуудтай холбоотой захиргааны асуудлыг зохицуулах зорилгоор сонгуулийн хороодыг байгуулна.

(6) Үндэсний сонгуулийн хороо нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд сонгууль, үндэсний санал асуулга, улс төрийн намын асуудалтай холбоотой дүрэм журмыг тогтоож болно. Мөн хууль тогтоомжид харшлахгүй бол дотоод журам тогтоож болно.

115 ДУГААР ЗҮЙЛ:

(1) Сонгуулийн хороо бүр сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах, үндэсний санал асуулгатай холбоотой асуудал зэрэг сонгуультай холбоотой үүрэг даалгаврын талаар холбогдох захиргааны байгууллагуудад шаардлагатай зааварчилгааг гаргаж болно

Үндэсний сонгуулийн комиссын бүтэц, зохион байгуулалтын тухай өгүүлье.

Нээлттэй, ил тод, чөлөөт сонгуулийг зохион байгуулах зорилгоор 3 үе шаттай бүтэцтэй ажилладаг.

- » Үндэсний сонгуулийн хороо
- » Орон нутгийн сонгуулийн хороо

» Хотын сонгуулийн хороо

Сонгуулийн хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дараах үүргийг хэрэгжүүлдэг.

- (1) Үндэсний болон орон нутгийн засаг захиргааны сонгуультай холбоотой асуудал
- (2) Үндэсний санал асуулгатай холбоотой асуудал
- (3) Улс төрийн намуудтай холбоотой асуудал
- (4) Итгэмжлэгдсэн сонгуультай холбоотой асуудал
- (5) Хууль тогтоомжоор тогтоосон бусад үүрэг

Үндэсний сонгуулийн комисс сонгуулийн маргаан, зөрчлийг хянан шинжлэх бүрэн эрхтэй. Мөн дэд хороог байгуулах бүрэн эрх олгогдсон. Тухайлбал,

8-5-р зүйл (Интернэтээр сонгуулийн тайлагнах зөвлөлдөх хороо)

Интернэт мэдээллийн хэрэгслийн вэб сайтад нийтлэгдсэн сонгуулийн мэдээг шударгаар хангах зорилгоор Интернэтээр сонгуулийн мэдээлэх зөвлөлдөх хороог байгуулж ажиллуулна.

8-7 дугаар зүйл (Сонгуулийн өргөн нэвтрүүлгийн мэтгэлцээний хороо)

Хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг шударгаар зохион байгуулах, явуулах зорилгоор Сонгуулийн өргөн нэвтрүүлгийн мэтгэлцээний хороог байгуулж ажиллуулна.

8-8 дугаар зүйл (Сонгуулийн санал асуулгын зөвлөлдөх хороо)

Сонгуультай холбоотой санал асуулгын бодитой, найдвартай байдлыг хангах үүднээс Сонгуулийн Судалгааны зөвлөлдөх хороог байгуулж ажиллуулна.

24 дүгээр зүйл (Үндэсний ассамблейн сонгуулийн тойрог заах хороо)

Үндэсний ассамблейн гишүүдийн сонгуулийн тойргийг шударгаар тогтоохын тулд Үндэсний ассамблейн сонгуулийн тойрог заах хороог байгуулан ажиллуулна.

Улс төрийн намын тухай хуулийн хүрээнд намын санхүүжилтийг хариуцан ажилладаг.

Улс төрийн намын тухай хуульд зааснаар Үндэсний сонгуулийн ерөнхий хороо

Улс төрийн намуудын бүртгэл, татан буулгах зэрэгтэй холбоотой ерөнхий асуудлыг зохицуулах

Ерөнхий захиргаа, улс төрийн санхүүжилт зэрэг улс төрийн намын үйл ажиллагааны гол асуудлуудад хяналт тавих эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

Улс төрийн намууд Төрийн албаны сонгуулийн тухай хууль болон улс төрийн бусад хуулийг зөрчсөн тохиолдолд зохицуулалт, хэрэгжилтийг хангана.

Улс төрийн намд санхүүжилт олгох чиглэлээр тайланг хүлээж авах, хянах, Улс төрийн намын санхүүжилтийн холбооны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

Шударга, ил тод, найдвартай байдлыг ханган ажиллахтай холбоотой Үндэсний сонгуулийн хороо санал хураалттай холбоотой менежментийн асуудлыг хариуцдаг. Үүнд:

САНАЛ ХУРААЛТЫН МЕНЕЖМЕНТ

- » Саналын хуудас үйлдвэрлэх
- » Удирдлагын боловсон хүчнийг сонгох, сургах
- » Сонгуулийн санал авах байр байгуулах, ажиллуулах
- » Санал хураах журамд хяналт тавих

САНАЛ ТООЛОХ МЕНЕЖМЕНТ

- » Удирдлагын боловсон хүчнийг сонгох, сургах
- » Санал тоолох төвийг байгуулж ажиллуулах
- » Санал тоолох үйл ажиллагаанд хяналт тавих
- » Сонгогдсон нэр дэвшигчдийг тодруулах, зарлах

ГАДААД УЛС ДАХЬ ИРГЭДИЙНХЭЭ САНАЛЫГ АВАХ МЕНЕЖМЕНТ

- » Хилийн чанад дахь сонгуулийн удирдлагын хороог бүрдүүлэх, ажиллуулах
- » Гадаадад санал өгөх мэдэгдэл, өргөдлийн менежмент
- » Гадаадад сонгуулийн санал авах байр байгуулах, ажиллуулах
- » Гадаадад санал өгөх журамд хяналт тавих

Хууль бус сонгуулийн сурталчилгааг хориглох, таслан зогсоох чиг үүргийг гүйцэтгэдэг. Тодруулбал,



- Хэргийн газарт нэвтэрч, холбогдох хүмүүсээс байцаалт авч, мөрдөн байцаалт явуулах, мөрдөн байцаалтад шаардлагатай холбогдох бичиг баримт болон бусад материалыг бүрдүүлж өгөхийг шаардаж болно.
- Сонгуулийн гэмт хэрэгтэй холбоотой нотлох баримтуудыг хэргийн газарт цуглуулж болно.
- Сонгуулийн гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаатай холбоотой хүмүүсийг байцаалт, мөрдөн байцаалтад шаардлагатай гэж үзвэл сонгуулийн хороонд ирэхийг шаардаж болно.
- Сонгуулийн тухай хуулийг илт зөрчиж, сонгуулийн эрх чөлөө, шударга байдалд ноцтой хохирол учруулахуйц үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай арга хэмжээг газар дээр нь авч болно.

NESDC (ҮНДЭСНИЙ СОНГУУЛИЙН САНАЛ АСУУЛГЫН ЗӨВЛӨЛДӨХ ХОРОО)-НЫ БҮРЭН ЭРХ:

Зөвхөн NESDC (Үндэсний сонгуулийн санал асуулгын зөвлөлдөх хороо)-д бүртгэлтэй сонгуулийн байгууллагууд үр дүнг нь олон нийтэд зарласан сонгуулийн санал хураалт явуулахыг зөвшөөрдөг.

Сонгуулийн санал хураалт явуулахын өмнө NESDC-д мэдээлэх ёстой.

Сонгуулийн санал хураалтын дүнг санал авах газар, санал авах хугацаа, түүврийн хэмжээ, түүвэр сонгох арга зэрэг дэлгэрэнгүй мэдээллийн хамт зарлаж, нийтэлсэн байх ёстой.

Сонгуулийн санал хураалтын дүнг санал хураах өдрөөс зургаа хоногийн өмнө санал хураалт хаах хүртэл зарлахыг хориглоно.

Санал авах байгууллагууд NESDC-аас холбогдох материалыг ирүүлэх хүсэлтийг биелүүлэх ёстой.

УЛС ТӨРИЙН НАМУУДАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ УДИРДАХ

Улс төрийн нам нь Үндэсний сонгуулийн хороонд бүртгүүлснээр байгуулагдана.

Бүртгүүлсэн өргөдлийн дэлгэрэнгүй мэдээлэл өөрчлөгдвөл 14 хоногийн дотор эрх бүхий сонгуулийн хороонд бүртгэлээ өөрчлөх хүсэлтээ гаргана.

Улс төрийн намууд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн гишүүдийн тоо, үйл ажиллагааны тоймоо дараа оны хоёрдугаар сарын 15-ны дотор эрх бүхий сонгуулийн хороонд тайлагнана.

Улс төрийн нам тодорхой болзол хангасан бол холбогдох сонгуулийн хороо дараах тохиолдолд бүртгэлээ цуцална.

- Байгууллагын хууль ёсны шаардлагыг хангаагүй.
- Дөрвөн жилийн хугацаанд улс орон даяар болсон сонгуульд оролцоогүй.
- Үндэсний ассамблейн сонгуульд суудал авч чадаагүй эсвэл нийт хүчинтэй саналын 2-оос доошгүй хувийг авч чадаагүй.

УЛС ТӨРИЙН НАМД САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

Үндэсний сонгуулийн хороо улс төрийн намд санхүүжилт олгоход дараах чиг үүргийг гүйцэтгэдэг.

- Улс төрийн нам хувь хүнээс хандив авсан тохиолдолд заавал мэдэгдэх ёстой.
- Улирал тутамд санхүүгийн тайлан гаргахаас гадна нэр дэвшигчийг бүртгэснээс хоёр хоногийн дараа тайлангаа гаргадаг.
- Үндэсний сонгуулийн хороо улс төрийн намын санхүүжилт, зардлын тайланг маш чухалчилж үздэг.

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ

Сонгогчдод сонгуулийн боловсрол олгох чиг үүргийг Үндэсний сонгуулийн хороо гүйцэтгэдэг.

Тодруулбал, ардчилсан иргэний ухамсрыг төлөвшүүлэх, сонгуулийн соёлын бат бөх суурийг бий болгох зорилготойгоор оюутнуудад сонгуулийн болон улс төрийн тогтолцооны талаар системтэй боловсрол олгодог. Сонгууль, улс төрийн нам, дэмжигч холбоодын үйл ажиллагаанд оролцож буй хувь хүмүүс, мөн их дээд сургуулийн оюутнууд, багш нар, олон нийтэд зориулсан сургалт явуулдаг.

Үндэсний сонгуулийн хороо нь сонгууль, ардчиллын асуудлаар форум зохион байгуулах, гадаадын сонгуулийн ажилтнуудад сургалт явуулах, туршлагаасаа бусад улс орнуудтай хуваалцах зэрэг олон улсын санаачилгад идэвхтэй оролцдог.



АНТОНИО СПИНЭЛЛИ: “Сонгуулийн удирдлагын байгууллагын хараат бус байдлыг хангах загвар”

Ардчилсан шударга байдлыг хамгаалахад сонгуулийн байгууллагын бие даасан, хараат бус байдал маш чухал гэдгийг энэхүү илтгэлээрээ хөндөнө.

Олон сонгуулийг судалж үзэхэд сонгуулийн шударга байдал, итгэл үнэмшил алдагдаж байна, олон иргэн сонгуульд оролцохоос татгалзаж сонгогчдын идэвх суларч байгаа гэдэг дүгнэлт гарч байна. Сонгуулийн луйвар, худал мэдээлэл, хууль бус үйлдэл зэргээс шалтгаалаад сонгуулийн үр дүнд иргэд эргэлздэг чиг хандлага байна.

2024 онд болсон сонгуулиудад судалгаа хийхэд 3 сонгогч тутмын нэг нь сонгуулийн чанар муудсан улсад амьдарч байна гэж хариулсан. Сонгогчдын оролцоо буурч, сонгуулийн маргаан эсэргүүцэл нэмэгдсэн.

2020-2024 оны хооронд сонгууль болгоны 1-д ялагдсан нам, эвсэл сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь хуваагдлыг нэмэгдүүлсэн. Нийгмийн хуваагдал, туйлшрал нэмэгдсэн нь сонгогчдын хурцадмал байдлыг бий болгож байна. Нийгмийн эв нэгдэл, хамтын шийдвэр гаргах мэдрэмж ч алдагдаж байгаа нь ажиглагдсан.

Сонгуулийн үйл явцад итгэх итгэл буурч байгаа нь туйлшрал, хурцадмал байдлыг өдөөж, эргэлзээг нэмэгдүүлж байгаа нь ардчилсан засаглалд заналхийлж байна.

Ийм хүнд нөхцөлд сонгуулийн шударга байдлыг хамгаалах нь улс орнуудад байнгын асуудал болж байна.

Сонгуулийн шударга байдалд итгэх итгэл нь Сонгуулийн удирдлагын байгууллагад итгэх олон нийтийн итгэлийн түвшнээс хамаардаг. Сонгуулийн итгэл үнэмшил нь сонгуулийн удирдлагын байгууллагын хараат бус, мэргэжлийн ур чадвараас шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл, энэ байгууллагын бие даасан, хараат бус, мэргэжлийн ажиллагаа сонгуульд оролцогч талуудын итгэлцлийг бий

болгоход маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сонгуулийн зохион байгуулалт, бие даасан байдал бүрэн хангагдсан байх тусам үр дүнгийн шударга байдал нэмэгддэг.

Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдал шударга, ил тод, хараат бус, олон улсын жишгээр сонгуулийг шударга явуулах, оролцогч талуудад тэгш хангах, маргааныг ил тод шийдвэрлэх, хууль дээдлэх ёсыг бататгах, хуулийг сахин биелүүлэх, иргэдийн итгэлийг хүлээж идэвхжүүлэхээс хамаардаг.

Хэрэв сонгуулийн байгууллагын удирдлага гадны нөлөөллөөс хамаарч, хараат байх юм бол сонгуулийн үйл явц итгэл үнэмшил багатай, шударга бус болох эрсдэлтэй. Тусгай ашиг сонирхол бүхий бүлгийн нөлөөнд автах, сонгогчдын бүртгэлд будилаан гарах, сонгох эрхийг нь зөрчих зэргээ ардчилсан засаглалын үндэс суурийг бууруулдаг. Тэр хэрээр иргэдийн оролцоог бууруулж, төрд итгэх итгэлийг сулруулж, улс төрийн тогтворгүй байдлыг бий болгодог.

Энэ бүхнээс дүгнэхэд СОНГУУЛИЙН УДИРДЛАГЫН ХАРААТ БУС загварыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хараат бус загварын хэмжигдэхүүн нь:

- Хууль эрх зүй хэмжигдэхүүн-Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан, хараат бус, шударга байдлыг хангасан хууль эрх зүйн бат бөх орчин орчин.
- Институтын хэмжигдэхүүн-Сонгуулийн удирдлагын байгууллагын бүтцийн хараат бус байдал, эрхзүйн орчин, удирдлагын томилгоо, санхүүжилтийн механизм, ерөнхий засаглал.
- Чиг үүрэг хэмжигдэхүүн-Сонгуулийн удирдлагын

байгууллагын зан төлөв, үйл ажиллагааны хараат бус байдал, хүлээсэн чиг үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдал.

- Харилцааны хэмжигдэхүүн-Сонгуулийн үйл явцад ил тод байдал, итгэлцэл, хариуцлагыг бий болгодог.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХЭМЖИГДЭХҮҮН

Эрх зүйн хувьд бие даасан байдлыг хуульчлах нь сонгуульд дур зоргоор хөндлөнгөөр оролцох, эрх баригчид, улс төрийн бүлгүүд зэрэг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах чухал ач холбогдолтой. Энэхүү зарчмыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомждоо тусгаснаар сонгуулийн удирдлагын байгууллагыг гадны дарамтаас хамгаалах, үйл ажиллагааг нь тодорхой болгох хамгийн том, бат бөх суурь болдог. Үндсэн хуулиараа сонгуулийн байгууллагыг хамгаалснаар засаглалын тулгын чулуу болгон бат бөх болгож байна гэсэн үг. Гүйцэтгэх, хууль тогтоох зэрэг бусад засаглалаас хамгаалж, бие даасан байдлыг хамгаалахын тулд Үндсэн хуульд сонгуулийн удирдлагын байгууллагын эрх мэдэл, чиг үүрэг, бүтцийг заадаг. Тухайлбал, Үндсэн хуулийн заалтууд нь улс төрийн хөндлөнгийн оролцооны эрсдэлийг бууруулж, сонгуулийн удирдлагын байгууллагын албан тушаалтныг аль нэг нам, улстөрчөөс хамааралгүй, ил тод болгох үндэслэл болох юм. Түүнчлэн сонгуулийн удирдлагын байгууллагын төсөв, нөөц зэрэг санхүүгийн бие даасан байдлыг хангаж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрдүүлдэг.

ИНСТИТУТИЙН ХЭМЖИГДЭХҮҮН

Сонгуулийн байгууллагын чиг үүрэг, хариуцлага, эрх мэдлийг тодорхой зааж өгснөөр тодорхойгүй байдлыг багасгадаг. Түүнчлэн сонгуулийн удирдлагын байгууллагын албан тушаалтныг аливаа дарамт, зүй бус нөлөөллөөс хамгаалж, үндэслэлгүйгээр ажлаас халагдахаас хамгаалсан хууль эрх зүйн зохицуулалтыг хийснээр айдасгүйгээр үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Сонгуулийн удирдлагын байгууллага тусгаар тогтносон улсад айдасгүйгээр оршин тогтнох боломжтой байх ёстой. Ил тод, шударга, хараат бус, хууль дээдлэх зарчмыг чухалчилж зөвхөн хууль, ёс зүй стандартад нийцэж ажиллах ёстой. Нөлөөнд өртөхгүйгээс гадна нийгэм, олон нийтийн өмнө өндөр хариуцлагаа

хүлээнэ. Айдасгүй, бие даасан байдал нь улс төрийн мэдрэмжтэй, зоригтой, шударга шийдвэр гаргахыг эрмэлзэх ёстой. Тусгайлсан төсвийг улс төрийн байгууллагуудаас хамааралгүйгээр хуваарилж, цаг тухайд нь олгодог байх ёстой. Санхүүжилтийг нь саатуулах заль мэхээс урьдчилан сэргийлсэн эх зүйн орчин байх учиртай.

Сонгуулийн удирдлагын байгууллагын дотоод нэгжүүд ямар чиг үүрэг хүлээх, бусад байгууллагатай хэрхэн харилцахыг тодорхой тусгасан байх ёстой.

Сонгуулийн удирдлагын байгууллагын албан тушаалтны томилгоог ил тод, хүртээмжтэй болгох шаардлагатай байдаг. Улс төрийн харьяаллаас илүү мэдлэг чадвар, мэргэшил, ёс зүйд нь анхаарах ёстой. Гүйцэтгэх удирдлага улс төрийн ямар нэг мөчлөгөөс өөр хугацаанд томилогддог байх нь зөв.

ЧИГ ҮҮРЭГ ХЭМЖИГДЭХҮҮН

Сонгуулийн удирдлагын байгууллага эрхэлсэн чиг үүргээ хараат бус, шударга, хуулийн хүрээнд хэрэгжүүлэх зарчим бөгөөд сонгогчдын бүртгэл, санал авах, тоолох, маргаан шийдвэрлэх зэрэг олон явцад энэ зарчим үйлчлэх ёстой. Ингэснээр олон нийтийн итгэлийг хүлээж, хадгалж чадна.

ХАРИЛЦААНЫ ХЭМЖИГДЭХҮҮН

Олон нийтийн итгэлийг хүлээх хамгийн чухал хэмжигдэхүүн бол харилцааны зарчим юм. Ил тод байх, итгэлцэл, хариуцлагын тогтолцоо бүхий орчинг бий болгох суурь нь харилцааны хэмжигдэхүүн байх ёстой. Үүнд дотоод засаглал, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааны хэлбэр, олон нийттэй хамтран ажиллах нээлттэй орчинг бүрдүүлэх ёстой.

Эцэст нь дүгнэхэд, хараат бус сонгуулийн удирдлага бүрэн бие дааж ажилладаг, хууль эрх зүй, санхүү, институтын хүчирхэг тогтолцоогоор дэмжигддэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ мерит зарчимд суурилсан чадварлаг манлайлалтай, шударга албан хаагчдаас бүрдэх ёстой. Мөн олон нийтийн итгэлийг хүлээсэн, бүх үйл ажиллагаандаа ардчилсан зарчимтай байж хараат бус ажиллана.

УЛСЫН
СУДАЛГААНЫ САН



II ХЭСЭГ:

Сонгуулийн эрх зүй,
Сонгуулийн процессын
эрх зүйн хөгжлийн
өнөөгийн байдал, салбар
эрх зүйг хөгжүүлэхэд
тулгамдаж буй асуудал





1. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ

Энэхүү харьцуулсан судалгааны илтгэлд сонгуулийн тогтолцоог өргөн агуулгаар нь биш, харин нэр дэвшигчдэд өгсөн сонгогчдын саналыг хэрхэн хуваарилах аргын тухайд буюу явцуу утгаар нь тодорхойлох болно. Орчин үед сонгуулийн тогтолцооны олон төрөл байдаг боловч сонгогчдын саналыг тоолсны дараа суудал хуваарилахад үндсэн хоёр төрлийн л хувилбар байна.

Түүхэн үүднээс үзвэл олныг төлөөлөх тогтолцооны үндэс нь олныг төлөөлөх зарчим (франц. majorite, англи. majority-олонх) ба энэ нь анх бий болсон арга ажээ. Тэгвэл хувь тэнцүүлэн төлөөлөх аргын онцлог нь сонгогчдын өгсөн саналын тоонд дүйцүүлж суудал хуваарилдагт оршино. Энэ зарчмын хүрээнд нэр дэвшигчдийг тойргоор биш, нэрсийн жагсаалтаар сонгодог байна.

Энэхүү хоёр үндсэн аргаас гадна аль аль шинжийг нь агуулсан дэд төрлийн, өөр олон арга үйлчилж байна.

Олон жилийн туршид олныг төлөөлөх тогтолцоог цор ганц зөв тогтолцоо гэж үзэж ирсэн бөгөөд нэр дэвшигч олны санал авсан л бол төлөөлөгчдийн байгууллагын мандат авах ёстой гэж үздэг байжээ. Хөгжлийн явцад энэхүү үзэл санаа зөв гэдэгт эргэлзэх болжээ. Учир нь гэвэл ялагдсан нэр дэвшигчид өгсөн санал ор тас үгүй болж төлөөлөгчдийн байгууллагад орох боломж хаалттай байсан ажээ.

Ийнхүү олныг төлөөлөх аргын үзэл санаа 18 дугаар зууны эцэс, 19 дүгээр зууны үед хүчтэй дэлгэрч эхэлсэн улсын бүрэн эрхт байдлын үзэл баримтлалд харшлах болжээ. Өөрөөр хэлбэл, ялагдсан нэр дэвшигчид өгсөн, "алга болсон" санал бүрэн эрхт байдлын уг чанарт нийцэхгүй байна гэж үзэх болжээ.

Хувь тэнцүүлэх төлөөллийн зарчмын талаар анх удаа нийгмийг аврах хорооны гишүүн Л.А.Сен-Жюста (1767-1794) 1793 онд Францын Конвент (хууль тогтоох байгууллага)-д үг

хэлэхдээ онцлон дурдсан байна.

Энэ аргыг анх удаа 1855 онд Данийн Фолкетинг (хууль тогтоох байгууллага)-ийн хэсэг гишүүнийг сонгохдоо хэрэглэжээ. Үүний дараахан 1893 онд Коста-Рикад, 1896 онд Австралийн Тасмани мужид энэ аргыг ашигласан байна.

Белги улс депутатыг сонгох хувь тэнцүүлэн төлөөлөх аргыг нэвтрүүлсэн Европын анхны (1898 онд) улс болсон байна. Үүний дараа Финланд 1906 онд, Швед 1907 онд энэ аргыг хэрэглэжээ. Дэлхийн нэгдүгээр дайны дараа Европын орнууд энэ аргыг өргөнөөр хэрэглэж эхэлсэн байна. Тухайлбал, 1919 онд Норвег, Герман, Итали, Швейцари, Австри, Люксембург, Чехословак, 1921 онд Ирланд, Мальдив хэрэглэж эхэлжээ.

Тэгвэл дэлхийн хоёрдугаар дайны дараа улам олон орныг хамрах болсон байна. Тодруулбал, Грек 1974 онд, Португал 1975 онд, Испани 1977 онд (өөрөөр хэлбэл, фашист дэглэмээс чөлөөлөгдсөн бүх орон) энэ аргыг хэрэглэж эхэлжээ. Өнгөрсөн зууны ерээд оноос Чехословак (1990), Румын (1990), Болгар (1991), Польш (1991), Унгар (1990), Албани (1992) энэ аргыг хэрэглэж эхэлсэн байна.

Хорьдугаар зууны эхнээс хувь тэнцүүлэн төлөөлөх арга нь 150 гаруй дэд төрөл болон хэрэгжиж байна. Ийм олон загвар бий болох үндэслэл нь аль болох олон сонгогчдын хүсэл эрмэлзлэлийг тусгах, төлөөлөгчдийн байгууллагыг сонгоход аль болохоор сонгогчдын саналыг орхихгүй байхад оршиж байна.

2. СОНГУУЛИЙН ОЛНЫГ ТӨЛӨӨЛӨХ ТОГТОЛЦОО

Төлөөлөгчдийн байгууллагад суудал авахын тулд олонхийн хэдэн санал авах вэ гэдгээс хамаарч энэхүү тогтолцоо нь дотроо бас ч олон дэд төрөлтэй байдаг аж.

Олныг төлөөлөх дийлэнх олонхийн (мажоритар) тогтолцоо

Үүний дагуу тухайн тойрогт санал өгсөн сонгогчдын тавиас дээш хувийн санал авсан байх шаардлагатай. Энэ аргын онцлог нь сонгогчдын талаас илүү хувийн санал авснаараа сонгуулийн төлөөллийн давуу талыг харуулж байгаа юм. Гэхдээ энд бас дутагдалтай тал бий. Энэ нь нөгөө талаар төлөөлөлгүй сонгогчдын хувь өндөр байдаг явдал юм. Бас нэг дутагдалтай тал нь зөвхөн сонгогчдын олонхийн санал авсан том намуудад ашигтай байдаг. Олон намын тогтолцооны үед энэ нь жижиг намуудад ач холбогдол, боломж муутай ба сонгогчдын санал сарних тул шаардлагатай олонхийн санал авч чаддаггүй байна. Дахин дахин сонгууль явуулж ихээхэн зардал гаргадаг тул улсууд үндсэндээ энэ аргаас татгалзах болжээ.

Харьцангуй олныг төлөөлөх тогтолцоо

Энэ бол бусад өрсөлдөгчдөөс илүү санал авах арга юм. Энэ арга байнга үр дүнтэй байдаг, учир нь гарцаагүй нэг нь илүү санал авсан байдаг.

Олныг төлөөлөх ялгамжтай тогтолцоо

Энэ бол урьд нь нэгэнт тогтоосон саналын тоо юм. Тухайлбал, 3/5, 2/3, 60%, 40% гэх мэт.

Энэ арга түгээмэл биш хэрэглэгддэг. Энэ аргыг Чилийн парламентын депутатын танхимын 120 гишүүнийг сонгоход ашигладаг байна.

3. ХУВЬ ТЭНЦҮҮЛЭН ТӨЛӨӨЛӨХ ТОГТОЛЦОО

Энэ нь дотроо маш олон дэд төрөлтэй бөгөөд намуудын авсан санал ойролцоо байх боломжийг бий болгодог байна.

Хувь тэнцүүлэн төлөөлөх аргын хувьд:

- a/** Улсын хэмжээнд сонгуулийн тойрог нэг байх;
- б/** Тойрогтой харьцуулбал тоолох арга нь илүү өндөр төвшинд хэрэгжсэн байхыг шаарддаг байна.

Хувь тэнцүүлэн төлөөлөх арга нь олон нам байгуулагдах, намууд оршин тогтнохыг эрмэлзэх, намууд парламентад аль болох олон суудал авахыг эрмэлзэх, сонирхолд түлхэц болж өгдөг. Парламентад намууд эвслийн Засгийн газар байгуулахад хүрдэг. Засгийн газарт хэт олон нам байх нь Засгийн газрын "нас богино байх", тогтвортой биш байх, эв нэгдэл тааруу байх шалтгаан болдог байна.

4. СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦОО

Энэ бол төлөөлөгчдийн байгууллагыг байгуулах олныг төлөөлөх ба хувь тэнцүүлэн төлөөлөх тогтолцоог хослох арга юм. Энэ нь түгээмэл биш боловч сүүлийн үед цөөнгүй хэрэглэх болж байна. Энэ аргыг Францын парламентын доод танхимын сонгуульд 1919, 1924, 1951, 1956 онд хэрэглэсэн байна. Сүүлийн үеийн жишээ гэвэл Албани, Унгар улсад хэрэглэсэн байна. Болгарт холимог системийг 1990 онд хэрэглэж, 1991 онд хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сольжээ. БНСУ-д 1981, 1985 онд мөн энэ аргыг хэрэглэж байжээ.

Холимог тогтолцоо нь дотроо бас олон дэд төрөлтэй байна. Энэ нь газарзүйн нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, тойргийн хүн амын их, багаас голчлон шалтгаалдаг байна.

Газар зүйн хувьд холимог тогтолцоо нь:

- a/** хувь тэнцүүлэх төлөөлөх давамгайлсан / пропорционал-мажоритар/
- б/** олныг төлөөлөх тогтолцоо давамгайлсан / мажоритар-пропорционал/
- в/** хувь тэнцүүлэн төлөөлөх, олныг төлөөлөх тогтолцоо адил төвшинд ижил хэрэглэх гэж ангилдаг байна.

Эдгээрийн аль нь илүү давамгайлах нь тухайн орны улс төрийн амьдралд багагүй нөлөөтэй байдаг аж.

Эцэст нь тэмдэглэхэд эдгээр тогтолцооны чухам алийг нь хэрэглэхийг тухайн үед сонгуулийн хуулийг батлахад улс төрийн хүчний харьцаа чухам ямар байхаас ихээхэн хамаардаг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ТҮЛХҮҮР ҮГ

- Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн хамгаалалт, Сонгуулийн төв байгууллага, үндсэн эрх
- Constitution court, protection of Constitution, conclusive ruling, central electoral authority,

ХУРААНГУЙ

Энэхүү илтгэлийн хүрээнд Үндсэн хууль ардчиллыг хамгаалахад онцгой үүрэгтэй Монгол Улсын Үндсэн хуулийн цэц болон түүний шийддэг маргааны харьяалалд байх Сонгуулийн ерөнхий хорооны зарим шийдвэр Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх асуудлаар болон Монгол Улсын иргэдийн үндсэн эрхтэй холбоотой сонгуулийн маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх процесс үйл ажиллагааны өнөөгийн байдлыг авч үзэн, төрийн эрх мэдэл хуваарилалтын ардчилсан зарчмыг хэрэгжүүлж, үндсэн хууль ёсны зарчим, үнэт зүйлийг хэрэглэн, эрх мэдэл бүхий байгууллагын дур зоргын үйлдлийг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудалд дүгнэлт хийж, сорилт бэрхшээлийг даван туулах боломжийг эрэлхийлсэн болно.

ОРШИЛ

Монгол Улсад 1992 онд ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар “засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн суурь зарчмыг ардчилсан ёсоор баталгаажуулсан билээ. Энэ үеэс “Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэх” болсон юм. Түүнчлэн “шууд болон төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” бөгөөд төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”. Энэхүү Үндсэн хууль ёсны зарчмуудыг иргэдийн эрх, эрх чөлөөний баталгаа болох үүднээс шүүхээр хамгаалах шаардлагыг ч шинэ Үндсэн хуульд суулгаж өгсөн байдаг юм. Тухайлбал, дээрх Үндсэн хуулийн зарчмууд зөрчигдвөл яах вэ? гэдэг асуултад хариулах цоо шинэ хяналтын механизмыг бий болгосон нь Үндсэн хуулийн цэц

хэмээх шүүх эрх мэдлийн байгууллага юм.

Үндсэн хуулийн хяналтыг /зөрчигдсөн эсэхийг хянадаг/ хэрэгжүүлэгч байгууллагуудыг дэлхий дахинд 2 үндсэн чиглэлээр бий болгожээ. Үүнд: а/ шүүхийн журмаар Үндсэн хууль зөрчигдсөн эсэхийг шүүх хянах, энэ нь дотроо -Ердийн шүүхийн журмаар /Эрүү, иргэний, захиргааны шүүхээр дамжуулан дээд шүүхэд/ хянах механизм, -Үндсэн хуулийн шүүх хянах гэсэн хоёр хэлбэртэй байдаг. б/ Үндсэн хуулийн хяналтын бусад байгууллага хянах хяналт, энэ нь дотроо мөн 2 хэлбэртэй байна. -Зөвлөл хэмээх шүүхийн бус байгууллага Үндсэн хуулийн зөрчлийн хяналтыг хэрэгжүүлэх, -Бусад гэсэн хэлбэртэй байдаг.

Монгол Улсад Үндсэн хуулийн шүүх хэмээх байгууллагыг байгуулсан нь бүхий л шинжээрээ Үндсэн хуулийн бие даасан шүүхийн хэлбэрийг илэрхийлдэг. Энэхүү шүүхийн хяналтын нэг объект нь Сонгуулийн төв байгууллагын шийдвэр хэмээн Үндсэн хуульд заасан байдаг билээ. Энэхүү илтгэлээрээ сонгуультай холбоотой маргааныг үндсэн 2 чиглэлээр Үндсэн хуулийн цэц хянаж байгаад дүн шинжилгээ хийж, өөрийн санал бодлыг илэрхийлсэн болно.

НЭГ. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ БА СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА

Оршил хэсэгт 1992 оны шинэ Үндсэн хуулиар цоо шинээр /өмнө нь төрийн тогтолцоонд ийм байгууллага байгаагүй/ бий болгосон Үндсэн хуулийн цэц хэмээх байгууллага Сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэрийг Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхээр хянаж болох тухай дурдсан. Үүнийг үндэслэн Сонгуулийн төв байгууллага нь үндсэн хуулийн байгууллага гэж үзэх нь ч бий. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэсэн байдаг билээ.

Мөн нэг онцлог зүйл нь шинэ Үндсэн хуулиар “иргэн”

“төр” хоёр нийгмийн харилцаанд тэнцүү эрхтэй талууд болсонд асуудлын мөн чанар оршиж байгаа билээ. Өөрөөр хэлбэл, иргэн Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргаж байгаа нь төрийн байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагааг хянаж, эрх бүхий байгууллагад зөрчлийг хянан шалгаж, шийдэж өгөхийг хүсэж буй хэрэг юм. Үндсэн хуульт ёсонд үүнийг иргэн хүн төртэй байгуулсан нийгмийн гэрээгээ өөрөө хянаж байна гэж үздэг байна. Үүнийг, иргэн төр хоёр жингийн туухайны 2 талд тэнцүү хэмжээнд байна гэж үздэг. Өөрөөр хэлбэл, тэнцүү эрх, үүрэгтэй талууд харилцаанд орж байна гэсэн үг билээ. Үндсэн хуульд зааснаар /66 дугаар зүйлийн 1-д: Үндсэн хууль зөрчсөн маргааныг: -иргэдийн өргөдөл мэдээлэл, -Эрх бүхий байгууллагын хүсэлт /Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор/-ээр үүсгэдэг

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2-т зааснаар:

- хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар **сонгуулийн төв байгууллага** /Сонгуулийн Ерөнхий Хороо/-ын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
- Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлыг хянан шийдвэрлэдэг.

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар Үндсэн хууль зөрчиж буй эсэхийг шалгуулахаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг хянан шийдвэрлэдэг байна.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2-т заасан байгууллагуудын шийдвэр, Төрийн өндөр албан тушаалтнуудтай холбогдох заалтыг хууль зүйн шинжлэх ухаанд “Үндсэн хуулийн хяналтын объект” гэж нэрлэдэг болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДСЭН СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР БОЛОН СОНГУУЛИЙН ХУУЛЬТАЙ ХОЛБОГДОХ МАРГААН

Өнгөрсөн 32 жилийн хугацаанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Сонгуулийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх, мөн Сонгуулийн ерөнхий хорооны гаргасан шийдвэр



Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар 20 гаруй маргаантай асуудлыг шийдсэн байдаг билээ.

Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлт гарч Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Захиргааны хэргийн шүүхийн харьяаллаас гаргасантай холбоотойгоор Үндсэн хуулийн цэц бүх шийдвэрийг хянан шийдвэрлэх ойлголт нөхцөлийг бүрдүүлсэн. 2019 онд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3 "Үндсэн хуулийн цэц зөвхөн санал хураалтын дүнг гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэртэй холбоотой маргаан"-ыг шийдвэрлэх зохицуулалт орсон. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц ч, Сонгуулийн ерөнхий хороо ч олон сорилттой тулгарч Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл баримтлал, үндсэн зарчмуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэн юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1996 онд "Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар" иргэн Д.Нармандах, Х.Баянмөнх нарын "Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 сарын 6-ны өдрийн 09 тоот тогтоолоор Д.Нармандах, Х.Баянмөнх нарыг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 болон 10-т байгаа "Монгол Улсын иргэн ...сонгогдох эрхтэй ... нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэг намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд нь хувь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглоно..." гэсэн өргөдлөөр маргаан үүсгэж, "УИХ-ын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 9 дүгээр тогтоолын Д.Нармандах, Х.Баянмөнх, Т.Етекбай нартай холбоотой заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна"¹ гэсэн 05 тоот дүгнэлт гаргажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1997 онд Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1997 оны 03 тоот тогтоол Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Иргэн Ч.Доржгочоо өргөдөлдөө: "П.Очирбат нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр 1990-1993 онуудад сонгогдож ... бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгч болох нь тодорхой байхад ...Сонгуулийн ерөнхий хороо 1997 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 03 тоот тогтоол гаргаж, П.Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгосон байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дугаар заалтыг зөрчсөн байна" гэжээ. Үндсэн хуулийн цэц маргааныг хянан шийдвэрлэхдээ "Үндсэн хуулийг зөрчөөгүй" гэж 03 тоот дүгнэлтээ² гаргажээ.

Хамгийн анх 1993 оны 12 дугаар сарын 22-нд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтууд Үндсэн

хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцсэн байдаг. Иргэн Ө.Сэргэлэн, Н.Баасанжав нар "1992 оны УИХ-ын сонгууль нь чөлөөт ардчилсан сонгууль болж чадсангүй. Үүний учир шалтгааныг Сонгуулийн хуульд сонгуулийн тэгш эрхийн зарчмыг тусгагдаагүй орхигдсон. Сонгуулийн хуульд тэгш эрхийн зарчмыг тусгаж өгөөгүйгээс түүнтэй холбогдсон олон харилцаа зохицуулалтгүй үлдэв. Хуульд хэдэн тойрог байх, нэг тойрогт хэдэн мандат ноогдох зэргийг тусгалгүй "Сонгуулийн олон мандаттай тойргоор зохион байгуулна. 8 дугаар зүйл", "Сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, ногдох мандатын тоог УИХ тогтооно. Мөн зүйлийн 2 дугаар хэсэг" гэх мэт тодорхой бус заалтуудыг оруулснаар хууль хэрэгжүүлэхэд алдаа гарах нөхцөлийг бүрдүүлсэн ..." зэрэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн хэмээн мэдээлэл гаргасан байна. Үндсэн хуулийн цэц 1993 оны 04 тоот дүгнэлтээрээ³ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 3, 35 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 38 дугаар зүйлийн 2 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна гэж үзсэн Ө.Сэргэлэн, Н.Баасанжав нарын өргөдөлд дурдсан гомдлыг хангах үндэслэлгүй гэж үзжээ. Мөн дүгнэлтийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын Их Хурлын Сонгуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд боловсронгуй болгох шаардлага байгааг үндсэн хуулийн цэц үгүйсгэхгүй байна" гэжээ.

1996 онд "Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг иргэн Ц.Цэрэнжээгийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө УИХ байгуулна. Аймгийн хүн амын тоо нь УИХ-ын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 2 хэсгийг, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтуудыг зөрчсөн байна" гэсэн өргөдлөөр маргаан үүсгэн Үндсэн хуулийн цэц 1996 оны 02 дүгнэлтээрээ⁴ Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна гэж үзжээ.

Мөн 1996 онд иргэн Б.Чулуунжав Үндсэн хуулийн цэцэд "Одоо мөрдөж байгаа парламентын сонгуулийн хууль ... Нэр дэвшсэн хүмүүсээс хэнийг ч сонгох хүсэлгүй иргэдийн саналын хуудсыг хүчингүйд тооцох нь тэр хүний сонгуулийн эрхийг хассантай ижил юм. Ийм тохиолдолд сонгогч саналын хуудсаа огт тэмдэглэхгүйгээр хайрцагт хийх үү, эсвэл нэр дэвшигчийн нэрсийг дарах уу гэдгийг хуулиар тогтоосон байх ёстой. ... Татгалзсан санал бүхий хуудсыг хүчингүй хуудсанд тооцож хасаад байвал нэр дэвшигчийн авсан саналын хувь, хэмжээ зохиомлоор өсөх болно. ... Сонгуульд оролцсон л бол заавал хэн нэг хүний төлөө саналаа өгөх ёстой гэж сонгогчийн шахаж болохгүй. Үндсэн хуульд заасан "Чөлөөтэй гэдэг зарчмын нэг тал

1 Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл. УБ., 2005. 233-237 дахь тал.

2 Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл. УБ., 2005. 293-296 дахь тал.

3 Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл. УБ., 2005. 53-61 дэх тал.

4 Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл 1. УБ., 2005. 208-212 дахь тал.

нь эс сонгох эрх чөлөө мөн. ...Ингэхлээр бүрэн татгалзсан саналыг хүчингүйд тооцсон заалтын талаар ул үндэстэй дахин бодож үзээд түүнийг хүчинтэй саналд тооцохоор хуульчилж, УИХ-ын сонгуульд өөрчлөлт оруулж өгөхийг ... хүсье" гэсэн өргөдлөөр маргаан үүсгэж 1996 оны 03 тоот дүгнэлтээрээ⁵ "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "санал огт тэмдэглээгүй бол ... саналын хуудсыг хүчингүйд тооцно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчжээ" гэж шийджээ.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэц 1998 онд иргэн Т.Ядамсүрэнгийн өргөдлөөр "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1, 16 дугаар зүйлийн 9, 14 дүгээр зүйлийн 1-ийг зөрчсөн эсэх" асуудлыг хянан үзэж маргаан үүсгэхдээ Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 06 тоот дүгнэлтээрээ⁶ "Үндсэн хууль зөрчөөгүй байна" хэмээн шийдвэрлэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2006 онд иргэн А.Эрдэнэцогтын мэдээллээр "Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай" маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Иргэн А.Эрдэнэцогт өргөдөлдөө "2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай / шинэчилсэн найруулга/ хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн заалтын дагуу холбогдох сонгуулийн хороодын гаргасан шийдвэр нь УИХ-ын сонгуультай холбогдсон зарим маргааны хувьд эцсийн шатны шийдвэр байх агуулгаар зохицуулагдсан нь, мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн заалтаар иргэний сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд органик хуулиар тавигдаж буй нийтлэг шаардлага болон захиргааны журамтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гаргасан шийдвэрийн талаарх маргааныг Үндсэн хуулийн цэцэд харьяалуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй" гэсэн заалтыг тус тус зөрчсөн"

гэжээ. Тэрбээр 2006 оны 5 дугаар сарын 22-ны өдөр ҮХЦ-д ирүүлсэн "...өргөдлийн шаардлагын үндэслэлийг ихэсгэх тухай мэдээлэлдээ: "УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т буй **"ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"** гэсэн заалтыг зөрчсөн. Үндсэн хуулийн эл заалт хууль тогтоох эрх мэдлийн үйл ажиллагаанд ч нэгэн адил баримтлагдах учиртай үндсэн хуулийн суурь зарчим мөн" хэмээсэн байх бөгөөд Үндсэн хуулийн цэц 2006 оны 05 тоот⁷ дүгнэлтийнхээ 1 дэх хэсгээр УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 57.1, 57.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй, 2 дахь хэсгээр 57.2, 57.3 дахь заалтууд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй, 57.6 дахь хэсгийн "Энэ хуулийн 41.9, 42.8-д заасан хөрөнгийг улсын орлого болгох шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах ба энэ талаар гомдол гарвал сум ба сум дундын, дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн байна" хэмээн шийдвэрлэжээ.

Үндсэн хуулийн цэц иргэн Р.Ууганбаатар, Л.Тэмүүжин, Р.Бурмаа, Д.Сүхгэрэл, С.Оюунтуяа нарын өргөдлөөр 2007 онд "УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай" маргааныг хянан хэлэлцсэн байна. Иргэн Р.Ууганбаатар, Л.Тэмүүжин нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө: УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2-т "Улсын Их Хурал олон мандаттай тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн санал авах өдрөөс зургаан сараас доошгүйн өмнө байгуулж, тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно", мөн зүйлийн 4-т "Тойрог байгуулах хүн амын тооны улсын дунджийг аймаг, нийслэлд ялгавартайгаар тогтооно" гэж заасан нь УИХ-ын гишүүд тодорхой харьцангуй тэнцүү тооны сонгогчдын мандаттай байх, сонгогч нэг л элчийг төлөөллөө болгон сонгох, сонгогч, нэр дэвшигчдийн алинд ч давхардал гаргахгүйгээр нийт сонгогчдын элч байх зарчмыг гажуудуулсан гэж үзэж байна. Сонгогчдод аймаг, нийслэлд амьдарч байгаагаар нь ялгавартай хандаж, шударга ёс, тэгш байдлын зарчмыг алдагдуулж сонгогчдын УИХ-д өөрийн

5 Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл 1. УБ., 2005. 213-215 дахь тал.

6 Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл 2. УБ., 2005. 55-62 дахь тал.

7 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл. III. УБ., 2012. 201-210 дахь тал.



элчийг сонгох эрхийг хясан боогдуулж, өөрийн сонгосон элчээс гадна хоёроос дээш хүнийг заавал сонгох албадлагыг бий болгосон байна. Дээрх заалтууд нь элч нар сонгогчдоо, сонгогчид элч нартаа ялгавартай хандан сөргөлдөх зэрэг сөрөг үр дагавартай байж болохыг үгүйсгэхгүй байна. Тэд мөн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 9, 29 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 47 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэж үзжээ. Иргэн Р.Бурмаа, Д.Сүхгэрэл, С.Оюунтуяа нар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.4, 29 дүгээр зүйлийн 29.2, 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэж үзжээ. Үндсэн хуулийн цэц эдгээр иргэдийн өргөдлийг нэгтгэн хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4, 25 дугаар зүйлийн 25.9, 10, 29 дүгээр зүйлийн 29.2, 36 дугаар зүйлийн 36.3, 37 дугаар зүйлийн 37.11.3, 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна” гэсэн 2007 оны 11 тоот⁸ дүгнэлтээ гаргажээ.

Иргэн М.Батсуурь, Ч.Өнөрбаяр, Б.Болд нар 2008 онд Үндсэн хуулийн цэц “Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн” хэмээн гомдол гаргаж, маргаан үүсгэн шалгасан байна. Үндсэн хуулийн цэц 2008 оны 06 тоот⁹ дүгнэлтээрээ “Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т “Нэр дэвшигч нь ... дараах шаардлагыг хангасан байна” гээд 27.4.3-т “ялгүй байх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн “... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, Хорин нэгдүгээр зүйлийн 3-т “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна” гэжээ. Дээр дурдагдсан үлдсэн заалтууд нь Үндсэн хууль зөрчөөгүй байна хэмээн шийдвэрлэсэн байна.

Бараг жил бүр ийнхүү Үндсэн хуулийн цэцэд Сонгуулийн хуультай холбоотой маргаан Үндсэн хуулийн цэцэд ирдэг байна. Энд бүгдийг тоочих боломжгүй учир цөөн хэдэн шийдвэрийн талаар дурдсан болно.

Мөн “хүний үндсэн эрхэд хамаарах Дээд шүүхийн болон Ерөнхий шүүгчийн шийдвэрүүд”-ийн талаар иргэд Үндсэн хуулийн цэцэд гомдол ирүүлдэг боловч Үндсэн хуулийн цэц, Дээд шүүх шийдсэн гэдгээр хүлээн авдаггүй. /Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2-т “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ” гэж заасан./ Үүний дараагийн өгүүлбэрт нь тэрхүү “...шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно” гэж заасан байна. Эндээс харвал шүүхийн эцсийн шийдвэр гэдэгт Хяналтын шатны шүүх буюу Улсын дээд шүүхээр хянуулах хүсэлт гаргаагүй, гаргасан ч дээд шүүх хянахаас татгалзсан давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүд мөн адил Үндсэн хуулийн цэцэд

хянагдах боломжийг эрж хайх шаардлага ч үүсэж байна. /Үүнийг Цэцийн тухай болон Цэцийн процессын хуулиар өргөтгөн зохицуулах шаардлагатай байгаа/.

Түүнчлэн Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 3 дугаар заалтад Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг “... хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх” хэмээн заасныг огт хэрэгжүүлээгүй өнөөдрийг хүрч байна. /Энэ заалтыг Цэцийн хуулиар дэлгэрүүлж өгөөгүй, мөн процессжүүлээгүй явж ирсэн./ Гэхдээ Үндсэн хуулийн цэц гагцхүү хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар л Дээд шүүхэд асуудал тавина.

ГУРАВ. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙН ҮР НӨЛӨӨ

Үндсэн хууль ардчиллыг хамгаалахад сонгуулийн төв байгууллага онцгой үүрэгтэй байдгийн нэг адил Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих Үндсэн хуулийн цэц /шүүх/ нь институтын хувьд Үндсэн хууль ёсыг төлөвшүүлэхэд онцгой үүрэгтэй байгууллага юм. Үндсэн хуулийн цэцийн тусгай буюу онцгой эрх мэдэл болох Үндсэн хуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргах, парламентын баталсан хуулийг хүчингүй болгох эрх мэдэл нь түүнийг Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болдог өвөрмөц онцлогтой. Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь процессын хуулиар зохицуулагддаг шүүх эрх мэдлийн байгууллага болон төлөвшиж байна.

Дэлхийн олон оронд Үндсэн хуулийн шүүх бол Үндсэн хуулийн хамгаалалтын тулгуур бөгөөд бусад төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч салаа мөчрүүдтэй харьцуулахад хууль зүйн дээд эрх мэдлийг өөртөө агуулсан институт гэж үздэг.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэж, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад оршино хэмээн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар зохицуулсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, үнэт зүйл, зарчмыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн гүйцэтгэх үүрэг онцгой ач холбогдолтой болохыг бид дээрх шийдвэрүүдээс харж болно.

Сүүлийн үед судлаачид Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хууль зүйн үр дагаварт шинжилгээ хийж байгаа нь ач холбогдолтой юм. Жишээ нь: Сонгуулийн холимог тогтолцоо Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэц 2016 оны 04 дүгээр сарын 22-нд буюу УИХ-ын сонгууль болохоос 2 сар 7 хоногийн өмнө гаргасан байна. Улс төрийн намууд, улс төрчид, судлаачид, олон нийтийн байр суурь Цэцийн дүгнэлтийг дэмжсэн, дэмжээгүй гэсэн хоёр хэсэгт хуваагдаад байх үед МУИС-ийн Хууль зүйн сургуулийн

8 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхэтгэл III. УБ., 2012. 516-525 дахь тал.

9 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхэтгэл IV. УБ., 2012. 87-92 дахь тал.

Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, Хууль зүйн ухааны доктор (LL.D) О.Мөнхсайхан МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, Хууль зүйн ухааны доктор (LL.D) О.Мөнхсайхан "Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн холимог тогтолцоог хориглоогүй" гэсэн сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж, Цэцийн дүгнэлтийн үндэслэлд анализ хийсэн байдаг. Үндсэн хуулийн цэц сонгуулийн холимог тогтолцоо Үндсэн хууль зөрчөөгүй гэж 2012 онд шийдвэрлэсэн үү, тийм бол ямар үндэслэлээр энэ шийдвэрээ 2016 од өөрчилсөн бэ, гэсэн асуултад тэрээр хариулт өгсөн байдаг. Энэ маргаан хөвөрсөөр 2023 онд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үндэслэн Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан билээ.

Үндсэн хуулийн цэц нь Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг иргэдийн өргөдөл, мэдээллээр маргаан үүсгэн шийдвэрлэхээс гадна Сонгуулийн хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх, иргэдийн үндсэн эрх сонгуультай холбогдон зөрчигдөж буй эсэх асуудлыг шийддэг билээ. Гэхдээ эдгээр маргааныг шийдэх эрх зүйн орчин тодорхой биш байх тохиолдлууд гарч байсан. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлт гарч Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Захиргааны хэргийн шүүхийн харьяаллаас гаргасантай холбоотойгоор Үндсэн хуулийн цэц бүх шийдвэрийг хянан шийдвэрлэх ойлголт нөхцөлийг бүрдүүлж байжээ. 2019 онд УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3 "Үндсэн хуулийн цэц зөвхөн санал хураалтын дүнг гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэртэй холбоотой маргаан"-ыг шийдвэрлэхээр болсон байна.

Мөн Улсын Их Хурлын сонгуулийн 15 дугаар тойрогт үүссэн маргаан олон нийтийн сонирхлыг нэлээд татаж байсан билээ. Тухайн маргаантай асуудлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэхдээ нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байдаг боловч хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийг "шүүхэд хамааралгүй асуудлаар дүгнэлт өгсөн" гэж үзээд давж заалдах шатны шүүхийн магадлалыг өөрчлөн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож байжээ. Энэ маргааны явцад /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны/ зөрчил гаргасан гэх нэр дэвшигч Ч, Х нарын УИХ-ын гишүүний бүрэн эрхийг зөвшөөрөх тухай асуудлыг Сонгуулийн ерөнхий хорооноос УИХ-д оруулан бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлжээ.

Дүгнэлт

Үндсэн хуулийн шүүхийн хяналтын объект болох Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэртэй холбоотой маргааныг Захиргааны шүүх шийдэх бусад төрлийн маргаанаас ялгагдах онцлогийг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүсэж байна.

Мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн процессын хэм хэмжээг тодорхой болгох шаардлагатай байна. Сонгууль нь тодорхой хугацаанд явагдаж дуусдаг онцлогтой. Энэ хугацаанд сонгуультай холбоотой гарч буй хүний үндсэн эрхтэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлэх процессын эрх зүйн зохицуулалт тодорхой байх шаардлагатай байна. Иргэдийн сонгох сонгогдох эрхтэй холбоотой маргаан сонгууль болоод дууссаны дараа шийдвэрлэгдэж байгааг Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь" төслийн тайлан, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын 2013, 2020 оны сонгуулийн ажиглалтын тайланд тодорхой дурдсан байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй юм.

ЦААШИД:

- Сонгуулийн хууль тогтоомж Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг Үндсэн хуулийн цэц хянахаас гадна иргэдийн үндсэн эрхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх боломжийг органик хуулиар нээж өгөх шаардлагатай.
- Сайн процессын хууль байгаад ч сонгууль шударга бус явагддаг, шударга бусын төлөө маргасан этгээдийг үл ойшоодог бол зөрчил арилахгүй улам ихэснэ. Өөрөөр хэлбэл, а/ сонгуулийн зардал өндөр байгаа тохиолдолд /зардлын төлөө хууль зөрчсөн үйлдэл, гэмт хэрэг гарахыг үгүйсгэх аргагүй/ Үндсэн хууль ардчиллыг хамгаалах боломжгүй болно, б/ нэр дэвшсэн нэр дэвшигчдээс хэнийг ч тухайн сонгогч сонгох боломжгүй гэж үзвэл яах вэ? гэдэг асуултад хариулт өгөх шаардлага ч байна.
- Үндсэн хууль боловсронгуй болон хөгжиж байх ёстой хууль. Гэтэл улс төрчийн хувийн ашиг сонирхлын үүднээс дур зоргоор асуудлыг шийдэж, Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад байвал яах вэ? гэх мэт шийдэл хүлээсэн асуудлууд олон байна.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг Үндсэн хуулиараа эрхэм зорилгоо болгон зорьсон Монгол Улсын хувьд Үндсэн хууль ардчиллыг хамгаалахад анхаарах, зөв зохицуулалтуудыг бий болгох, иргэдийнхээ үндсэн эрхийг хамгаалж, үндсэн хууль ёсны үнэт зүйлийн хүрээнд эрх мэдэлтний дур зоргын үйлдлийг таслан зогсооход Монгол Улсын Үндсэн хуулийн цэц болон Сонгуулийн ерөнхий хороо хэмээх байгууллагууд аль аль нь онцгой үүрэгтэй байх шаардлага ч зүй ёсоор тавигдаж байна.



Бид өдөр бүр сонголттой тулгарч байдаг эдгээр олон сонголтлоос хүний улс төрийн эрхийн сонголт хийх чөлөөт боломж нь гагцхүү Ардчилсан засаглалын хэлбэрт байдаг. Энэ ч утгаараа сонгууль нь Ардчилсан засаглалын хэлбэрийн үнэт зүйл болдог. 1992 онд Монгол Улсад анх удаа ардчилсан сонгуулийн шинэ үе эхэлж иргэний сонгох сонгогдох эрхийн эрх зүйн орчныг баталгаажуулж, чөлөөт ардчилсан сонгууль жинхэнэ утгаараа хэрэгжиж эхэлсэн.

Сонгуулийн тогтолцооны төгс хувилбар гэж байхгүй бөгөөд тухайн улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, сонгогчийн тоо, газар нутгийн хэмжээ, байршил гэх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан улс орон бүр өөрийн орны онцлогт нийцсэн сонгуулийн тогтолцоог хэрэглэж, шаардлагатай гэж үзсэн нэмэлт өөрчлөлт хийж боловсронгуй болгож байна. Учир нь сонгуулийн мажоритар болон пропорциональ тогтолцоо нь өөрийн давуу болон сул талуудтай. Ийм ч учир дэлхийн улс орнууд сонгуулийн тогтолцооны давуу талыг аль болох хадгалж авч үлдсэн, сул талыг багасгасан тэрхүү боломжит хувилбарыг эрэлхийлж сонгуулиа зохион байгуулахыг эрмэлзэж байна. Энэ нь ардчилсан нийгмийн үнэт зүйлийн нэг болох ардчилсан сонгуулийн үндсэн зарчмыг бодитоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой байдаг.

Монгол Улсын хувьд мөн адил сонгуулийг тогтолцоог тухай бүр өөрчилж, сонгуулиа зохион байгуулж байсан. 2023 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулах, Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох сонгуулийн үндсэн тогтолцоо, сонгох журмыг хуульчилж, мөн Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж хуульчилсан нь сонгуулийн эрх зүйн тогтвортой байдлыг хангах суурь эрх зүйн орчныг бүрдүүлсэн юм.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа нь хэн, хэзээ, ямар үйл ажиллагааг, ямар хугацаанд, хэрхэн хийсэн байх

шаардлагатайг нарийвчлан тогтоосон хууль, хэм хэмжээний актын дагуу үйлдэгддэг, нэг үйл ажиллагаа нь нөгөө үйл ажиллагаанаасаа шууд хамааралтай, тодорхойлсон хугацаанд тасралтгүй үргэлжлэх процесс байдаг. Хэрэв энэхүү процесс үйл ажиллагааны аль нэгийг бүрэн гүйцэт, хуулийн дагуу хийгээгүй бол дараагийн үйл ажиллагааг хийх боломжгүй болох өндөр эрсдэлтэй, нарийн зохион байгуулалт бүхий процесс үйл ажиллагаа байдаг.

Иймд сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны энэхүү онцлогийг харгалзан сонгуулийг ил тод, шударгаар явуулах процесс болон сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар судлах хэрэгцээ шаардлага их байна. Тухайлбал сонгууль зохион байгуулах процесс үйл ажиллагааны онцлогт нийцсэн маргаан хянан шийдвэрлэх эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай юм.

Сонгуулийн эрхийн хэрэгжилтийн баталгааны нэг гол механизм нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо болдог. Энэ ч утгаараа сонгуулийн эрх болон улс төрийн бусад эрхийг өөр, өөр арга замаар хамгаалдгаас шалтгаалж дэлхийн бусад улс орнууд сонгуулийн маргааныг Үндсэн хуулийн шүүх, Захиргааны хэргийн шүүх, Сонгуулийн байгууллага хянан шийдвэрлэх харьяаллуудыг тогтоож өгсөн байна. Энэ талаар Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн АСДҮОУХ 2011 онд гаргасан “Зүй ёсны сонгууль” гарын авлагад дурдсанаар бол сонгуулийн эрхийг хамгаалах буюу маргааныг хянан шийдвэрлэх субъектуудыг сонгуулийн байгууллага, шүүх байгууллага, олон улсын байгууллага гэж ангилан үзжээ.

Харин Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц хэлэлцэхээр харьяаллыг тодорхойлсон. Гэвч нөгөө талаас сонгуулийн төв байгууллагын шийдвэр нь захиргааны акт учраас захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудалд мөн хамаарч байдаг.

Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааны харьяаллын талаар судлаачид нэгдсэн байр суурь, тодорхой шийдэлд хүрээгүй маргаатай явсаар ирсэн. Тухайлбал сонгуулийн төв байгууллагын гаргасан

ямар шийдвэр Үндсэн хуулийн цэцийн харьяалалд байх, ямар шийдвэр нь захиргааны хэргийн шүүхийн харьяаллын байх асуудлаарх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүд, мөн судлаачдын байр суурь зөрүүтэй байдаг.

Тухайлбал, судлаачид 1992-2015 онуудад зохион байгуулсан сонгуулиуд маргаан ихээр дагуулж байсан шалтгаан нь тухайн үеийн хууль тогтоомжид маргааныг хянан шийдвэрлэх процесс тодорхойгүй байсантай холбон тайлбарлаж байсан. Судлаачдын дунд маргаантай байсан энэхүү асуудлаар Үндсэн хуулийн цэцээс гурван ч удаа дүгнэлт гарсан бөгөөд эдгээр дүгнэлтүүд нь сонгуулийн маргааныг Үндсэн хуулийн цэц дангаар хянан шийдвэрлэх, Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх, Сонгуулийн байгууллага хянан шийдвэрлэх зэрэг дүгнэлт гарсан нь цаашид энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн харьяаллын хувьд тодорхойгүй, судлаачдын дунд маргаантай нөхцөлд хүргэж байв.

2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдаж 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар Захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх маргааны төрлүүдийг жагсаалтын зарчмаар тодорхойлсон. Ингэхдээ Монгол Улсын Засгийн газар болон Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр хуульчилсан. Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээр "Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг тус тус зөрчсөн" гэж дүгнэсэн байдаг. Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийн талаар хууль зүйн доктор О.Мөнхсайхан Засгийн газрын шийдвэр болон Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх эсхүл Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх хэргийн харьяаллын асуудлыг "Захиргааны шүүхийн хяналтаас гарч, дураараа авирлах гэсэн Засгийн газрын хүслийг Улсын Их Хурал зогсоож чадна" эрдэм шинжилгээний нийтлэл өгүүлэлдээ хөндөж авч үзсэн.

Мөн Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор А.Эрдэнэцогт "Монгол Улсын захиргааны процессын эрх зүй" бүтээлдээ сонгуулийн маргаан тэр дундаа Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг хөндөгдөж буй сонгуулийн эрхийн объектив болон субъектив талаас нь дүгнэлт өгч, улмаар хэргийн харьяаллыг тодорхойлох талаар дүгнэж бичсэн байдаг. Тухайлбал "Иргэний сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэх талаар органик хуулиар тогтоосон захиргааны журмыг Сонгуулийн ерөнхий хороо зөрчсөн эсэх маргааныг Цэц, ердийн шүүхтэй зэрэгцэн хянах нь Үндсэн хуулийн утга агуулгад нийцэхгүй бөгөөд дээд хяналтын ач холбогдлыг бууруулж байна." гэж, мөн "Улсын Их Хурлын сонгуульд санал өгөх сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэнтэй холбогдсон гомдлын талаарх сонгуулийн тойргийн хороо,

түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэртэй холбогдсон маргаан, Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай сонгуулийн тойргийн хороо, түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэртэй холбогдсон маргаан. Эдгээр нь үндсэн хуулийн маргаан бус, харин захиргааны маргаан болно. Уг маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх онол, эрх зүйн бүрэн үндэслэлтэй төдийгүй захиргааны хэргийн шүүх байгуулагдсан цаг мөчөөс эхлэн энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх талаар зохих туршлагыг хуримтлуулж ирсэн юм. Иймд Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан захиргааны акт нь Үндсэн хуулийг бус, харин ердийн хуулийг зөрчсөн тухай маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодотгон сэргээн тогтоох нь иргэний үндсэн эрхийн хууль зүйн баталгааг хангахад чиглэгдсэн дорвитой алхам болох бөгөөд эрх зүйт төрийг төлөвшүүлэх, иргэний нийгмийг цогцлуулах үйлсэд бүрнээ нийцнэ." гэж тус тус дүгнэсэн байдаг.

Тодруулбал, хэдийгээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 81 дүгээр зүйлийн 81.3-т зааснаар Үндсэн хуулийн цэц зөвхөн санал хураалтын дүнг гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбоотой маргааныг Үндсэн хуулийн эрх зүйн маргаан гэж зөв дүгнэж Үндсэн хуулийн цэц харьяалан шийдвэрлэхээр хуульчилсан боловч мөн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т "Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.", 74.3-т "Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу тойрогт хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ." 74.4-т "Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ." гэж санал хураалтын дүн гаргах харилцааг зохицуулжээ.

Гэтэл 81 дүгээр зүйлийн 81.3-т "санал хураалтын дүнг гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр" гэж 74 дүгээр зүйлд заасан дүн гаргах 2 төрлийн шийдвэр болон дүнг өргөн барих шийдвэр нийт 3 төрлийн шийдвэрийг нэг томъёоллоор тодорхойлон хуульчилснаас үүдэн Үндсэн хуулийн цэц болон Захиргааны хэргийн шүүхэд хэргийн харьяаллын хувьд дахин ойлгомжгүй байдалд хүргэж байсан.

Харин 2023 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр дээрх харьяаллын тодорхой бус байдлыг зохицуулсан. Тодруулбал хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3 дэх хэсэгт өөрчлөлт оруулан "Энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн

цэц хянан шийдвэрлэнэ.” гэж хуульчилснаар сонгуулийн төв байгууллагын шийдвэр холбогдох маргааны харьяаллыг нэг мөр шийдвэрлэжээ.

Дээрхээс үзвэл сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үндсэн хуулийн процессын эрх зүй болон захиргааны процессын эрх зүйн хүрээнд тусгайлан авч үзэх, судлах шаардлагатай юм.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад үүссэн маргааныг хянан шийдвэрлэх харьяаллаар зааглан авч үзвэл:

1.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ:

Бүх шатны сонгуулийн хороодын үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой гомдлыг шатлан захирагдах зарчмын дагуу дээд шатны сонгуулийн хороод хянан шийдвэрлэнэ.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т “Сонгуулийн хороод энэ хуульд заасны дагуу шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргана.”

2.

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ:

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн эсэх зөрчлийг 9 эрх бүхий албан тушаалтан, байгууллага хянан шийдвэрлэнэ

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан Сонгуулийн хуулийг зөрчих 36 төрлийн зөрчлийг хуульчилсан. Уг зөрчлүүдийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зааснаар Сонгуулийн хуулийг зөрчих дээрх зөрчлүүдийг Тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан, Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Татварын улсын байцаагч, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч, Монгол банкны хянан шалгагч, Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, Эрүүгийн хэргийн шүүх зэрэг нийт 9 эрх бүхий албан тушаалтан, байгууллага хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоосон байна.

3.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ:

Эрүүгийн хуулийн 14 дүгээр “Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг” бүлэгт нийт 5 төрлийн гэмт хэргийг хуульчилсан. 14.5 дугаар зүйл.Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх, 14.6 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад

СЫН ЭРХ ЗҮЙ”

law

ин дарга



илүү санал өгөх, 14.7 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах, 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах, 14.9 дүгээр зүйл. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах зэрэг нийт 5 төрлийн гэмт хэргийг хуульчилсан байна.

4.

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.3-т зааснаар Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, мөн хуулийн 112.4.1-т зааснаар



аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргааныг захиргааны хэргийн анхан шатны шүүх тус тус тусгай журмаар хянан шийдвэрлэхээр хуульчилсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81.4-т “Энэ хуулийн 81.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.”, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3-т “Сонгуулийн хорооны шийдвэрт холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4-т “Энэ хуулийн 80.3-т зааснаас бусад

Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж тус тус сонгуулийн хорооны шийдвэрт холбогдох захиргааны хэргийн хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тодорхойлон хуульчилсан байна.

5. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ХАРЬАЛЛЫН МАРГААН:

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн

хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргана.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81.3-т “Энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.3-т “Энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.” гэж тус тус Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан сонгуулийн дүнд холбогдох маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх харьяаллыг тодорхойлон хуульчилсан байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.3-т зааснаар Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, мөн хуулийн 112.4.1-т зааснаар аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргааныг захиргааны хэргийн анхан шатны шүүх тус тус журмаар хянан шийдвэрлэхээр зохицуулж, давж заалдах шатны шүүх сонгуулийн маргааныг 40 хүртэл хоногийн дотор анхан шатны журмаар, Улсын Дээд шүүх 21 хүртэл хоногийн дотор давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Гэтэл хэргийн оролцогчдын хувьд хяналтын журмаар гомдол гаргах эрх хязгаарлагдаж байна гэж маргах боломж үүсэж байдаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т “Улсын дээд шүүх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж хуульчилсан тул мөн хуульд заасан хяналтын журмаар гомдол гаргахтай холбоотой зохицуулалт хамаарахгүй юм.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн холбогдох маргааныг захиргааны хэргийн 2 шатны шүүх хянан шийдвэрлэх хугацаа нь 68 хоног болж байна. Харин орон нутгийн сонгуультай холбоотой гомдол маргаан нь 3 шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэж байна.

2012 оноос 2024 оны ээлжит сонгуультай холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэгдсэн маргааныг шийдвэрлэсэн хугацааны хувьд захиргааны хэрэг үүсгэснээс хойш 2 хоногоос 10 сарын хугацаанд шийдвэрлэсэн байдаг.

Хэдийгээр сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх журмыг тусгайлан тогтоож, ердийн бусад захиргааны хэрэг маргаантай харьцуулахад багасгасан хугацаанд хянан шийдвэрлэхээр хуульчилсан боловч хянан шийдвэрлэх хугацааны хувьд дээр дурдсанаар сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хугацаатай уялдуулах шаардлага байгаа нь харагдаж байна. Мөн нөгөө талаас нь авч үзвэл сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад гарч буй маргааныг

хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байдаг. Тухайлбал хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаа, мөн шүүхэд нэхэмжлэл гаргасан хугацаанаас хамаарч санал хураалтын үр дүн гарсны дараа зөрчигдсөн эрхийг сэргээх шийдвэр гаргасан тохиолдолд тухайн тойрогт явагдсан сонгуулийг дахин явуулах, эсхүл тухайн тойргоос сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрхийг дуусгавар болгож нөхөн сонгууль явуулах эсэх асуудлыг холбогдох сонгуулийн хууль болон сонгуулийн үр дүнд сонгогдсон нэр дэвшигчийн эрх зүйн байдлыг тодорхойлж буй хууль тогтоомжтой уялдуулан тодорхойлох шаардлага байдаг.

Жишээ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлд төлөөлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох үндэслэлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг батлах үед буюу 2020 оны 1 дүгээр сард Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3-д заасан үндэслэлээр Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр хүчингүй болсон бол төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох, улмаар нөхөн сонгуулийг зохион байгуулах зохицуулалтыг хуульчилсан. Уг зохицуулалт нь 2020 оны 12 дугаар сард батлагдсан Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад мөн тусгалаа олж хуульчлагдсан байдаг. Мөн уг үндэслэлээр төлөөлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох тохиолдолд бусад үндэслэлийн адилаар Хурал санал хураалт явуулахгүй байхаар хуульчилсан нь маргаан бүхий асуудлыг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн биелүүлэх эрх зүйн хөшүүргийг бүрдүүлсэн юм.

Сонгууль зохион байгуулах процесс үйл ажиллагааг нарийвчлан сайжруулах, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах гэх мэт уг салбарт нарийвчлан судлагдаагүй, судлах шаардлагатай маш олон чухал сэдэв, асуудал байгаа бөгөөд өнөөдөр энд цугласан эрдэмтэн судлаачид, төлөөлөгч, оролцогч Та бүхнийг сонгуулийн эрх зүйн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх сэдлийг төрүүлэх нь бидний зохион байгуулж буй энэхүү бага хурлын бас нэгэн зорилго юм.

Сонгуулийн ерөнхий хорооны хувьд мөн судалгаа шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээлэл, баримтыг эргэлтэд оруулах, судлаач олон нийтэд нээлттэй мэдээлэх, хэрэглэхэд ойлгомжтой, хялбар байлгах тэрхүү боломжийг бүрдүүлж ажиллахыг зорилгоо болгон ажиллаж байгааг энэ дашрамд Та бүхэнд дуулгахад таатай байна.



НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ, ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

НЭГ. СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛООР ДАМЖУУЛАН АРДЧИЛЛЫГ ХАМГААЛЖ БОЛОХ УУ?

Үндсэн хуульт ардчиллыг чөлөөт, шударга сонгуульгүйгээр төсөөлөх боломжгүй. Яагаад гэвэл ардчиллыг бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх гол хүчин зүйлийн нэг бол чөлөөт, шударга сонгууль юм.¹ Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламентыг чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийн үндсэн дээр ард түмэн өөрсдийн итгэл үнэмшил, хараат бус, чөлөөт сонголтоороо байгуулах нь Үндсэн хуульт ардчилал оршин байгаа эсэхийг тодорхойлох нэгэн гол хүчин зүйл юм.² Ард түмний сонгосон хүмүүс хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг учраас эдгээр эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн эрх ардчилсан сонгуулийн дүнгээр улс төрийн нам, эвслийн хооронд шилждэг талаар доктор О.Мөнхсайхан дурджээ. Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж Үндсэн хуулиа даяар олонд зарлан тунхагласан билээ. Ийнхүү ардчилсан нийгэм, улс төрийн тогтолцоонд шилжсэнээс хойш Улсын Их Хурлын болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг 9 удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийг 8 удаа зохион байгуулж, ардчилсан сонгуульд оролцож, ардчиллын соёл, оролцоонд суралцсаар байна.

Сонгууль гэдэг хууль зүйн ойлголтынхоо хувьд Монгол Улсад орчин цагийн сонгуулийн тухай үзэл санаа нэвтэрч байсан үе³ буюу 1921 оны 3 дугаар сард гаргасан “Тунхаглан зарлах тогтоол бичиг”-т “Монгол Улс үүрд байх Засгийн газрыг олж, үндсэн цааз дүрмийг тогтоож **сонгуулийг**

эрхэлсэн гүрэн байгуулна”⁴ гэснээс эхлэлтэй гэж Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг баригч, доктор, профессор Б.Чимид тодорхойлсон байдаг.

Сонгууль бол ардчиллын маш чухал элемент, харин ардчиллын зорилт нь хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, ямар нэг ялгаварлалгүйгээр эдлүүлэх Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн пактын зарчмуудыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Манай улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлд “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд “...сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” эрхийг аливаа алагчлалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр эдлэхээр заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан. Эндээс харахад аливаа засгийн эрх мэдэл нь ард түмний “жинхэнэ хүсэл зоригийн илэрхийлэл”, сонгогчдын өөрсдийн нь “бүтээл” байх бөгөөд засгийн эрх барих энэ эрхээ сонгуулиар дамжуулан хэрэгжүүлдэг.

Сонгогчид сонгуулийн үйл явцаар дамжуулан сонгох эрхээ үр дүнтэй хэрэгжүүлж, улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэхэд сонгогчдын боловсрол хамгийн чухал. Сонгогч сонгуулийн үйл явцад оролцож, саналаа өгөхийн тулд зарим зүйлийг заавал мэдсэн байх шаардлагатай. Энэ нь санал өгөх байранд ирж, санал өгөхөд сонгогч

1 Д.Бат-Эрдэнэ. Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг. Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал. УБ, 2024 он. 9 дэх тал

2 Д.Бат-Эрдэнэ. Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг. Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал. УБ, 2024 он. 5 дэх тал

3 Б.Чимид. Сонгуульд суралцахуй. УБ. 2008 он, 26 дахь тал

4 “Ардын засгаас 1921-1924 онд авсан хувьсгал арга хэмжээнүүд” (эмтхтгэсэн Ц.Насанбалжир) ШУАК. УБ, 1954 он

бүрийн мэдвэл зохих сонгуультай холбоотой үндсэн мэдлэг, мэдээлэл юм. Уг мэдлэгийг олгох нь сонгогчдын боловсролын нэг үүрэг бөгөөд сонгуулийг шударга, чөлөөтэй явуулах зорилготой. Сонгогчдын боловсролын ачаар сонгогчид сонгуулийн үеэр аливаа хууль бус амлалт, ухуулга сурталчилгаанд амархан хууртагдахгүй, хэрсүү байж, аливааг олон талаас харах чадвартай болохоос гадна улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа, суртал ухуулгад “тэсвэртэй” болдог. Хэрэв сонгогчид сонгуулийн үйл явцад оролцоход бэлэн биш бол сонгуулийн үр дүнд бий болсон институтын хууль ёсны байдал, төлөөллийн чанарт эргэлзээ төрөх нь дамжиггүй. Иймээс зөвхөн сонгогчдын боловсролоор дамжуулан ардчиллыг бий болгож чадахгүй ч түүнийг хамгаалж чадна гэж зарим судлаачид үздэг. Өөрөөр хэлбэл, сонгогчдын боловсрол нь ардчиллыг идэвхжүүлж, бэхжүүлэх иргэдийн суурь хандлага, зан үйл, мэдлэгийг бий болгодог.

ХОЁР. “СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ” ГЭСЭН ОЙЛГОЛТЫГ ТОДРУУЛАХ НЬ

Сонгогчдын боловсрол гэдэг нь сонгогчдод сонгуульд санал өгөхийн ач холбогдлыг танин мэдүүлж, тэднийг сонгуульд бэлэн байлгахад чиглэсэн ойлголт бөгөөд ардчилсан сонгууль дахь иргэдийн хандлага, зан байдлыг илтгэдэг. Сонгогчдын боловсрол нь хэний төлөө санал өгөх вэ гэхээс илүүтэй хэрхэн санал өгөх вэ гэдэгт төвлөрдөг.

Ихэнх тохиолдолд **сонгогчдыг мэдээллээр хангах**⁵ (voter information), **сонгогчдын боловсрол** (voter education), **иргэний боловсрол** (civic education) гэсэн нэр томъёог нэг дор хэрэглэх хандлага түгээмэл байдаг. Сонгууль, ардчиллыг дэмжих боловсролын үйл ажиллагаа гэдэг утгаараа харилцан уялдаатай байх нь зүйн хэрэг ч эдгээр ойлголтуудыг хооронд нь ялгаж салгаж ойлгох шаардлагатай гэдгийг судлаачид онцолдог.⁶ Яагаад гэвэл хөтөлбөрийн агуулга, үргэлжлэх хугацаа, хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэхэд оролцдог байгууллагууд нь ялгаатай байдаг.

“Сонгогчдыг мэдээллээр хангах” гэдэг нь санал өгөх огноо, саналаа өгөх цаг, газар, сонгуулийн төрөл, сонгогчдын бүртгэл зэрэг сонгогчдод саналаа өгөх боломжийг олгох үндсэн мэдээллийг хүргэх явдал. Сонгууль бүрд, түүнчлэн сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн систем, саналаа өгөх арга, хэлбэр өөрчлөгдөх бүрд сонгогчдод хүргэх мэдээлэл өөр, өөр байж болно. Энэ ажлыг түргэн шуурхай гүйцэтгэх нь чухал ч хангалттай төлөвлөх нь илүү амжилттай байхад нөлөөлнө. Энэ төрлийн мэдээллийг сонгуульд оролцож буй бүхий л талууд сонгогчдод хүргэх ёстой. Энэ хэсэгт сонгогчдод зайлшгүй өгөх үндсэн гол мэдээлэлд дараах агуулгыг улс орнууд онцолдог байна.⁷ Үүнд,

1. Сонгуульд оролцохын тулд урьдчилан бүртгэл хийх шаардлагатай эсэх? Ихэнх улс орнуудад санал хураах өдрөөс өмнө бүртгүүлсэн байхыг шаарддаг.

2. Саналын хуудсыг хэрхэн зөв бөглөх вэ? Саналын хуудсыг буруу бөглөснөөр тухайн хүний санал хүчингүйд тооцогдох, буруу тоологдох эрсдэлтэй. Тиймээс саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар мэдээлэл чухал.
3. Сонгуулийг ямар системээр зохион байгуулах вэ? Саналаа өгөх нь сонгуулийн эцсийн үр дүнд хэрхэн нөлөөлөхийг сонгогч мэдэж байх нь чухал. Тухайн сонгууль ямар системээр явж байгаагаас хамаарч сонгогчдын санал хэрхэн тоологдох нь шалтгаалдаг.

“Сонгогчдын боловсрол” гэдэг нь сонгогчдын сонгуульд бүрэн оролцох урам зориг болон бэлэн байдлыг шийдэхэд илүүтэй анхаардаг. Энэ нь сонгууль ба ардчиллын хамаарал, ардчилсан сонгуулийг явуулахад шаардлагатай нөхцөл, хүний үндсэн эрх болон сонгох эрхийн хоорондын уялдаа холбоо санал бүр яагаад чухал вэ, сонгогчийн эрх үүрэг, хариуцлага, санал өгөх, саналын хуудасны нууцлал, сонгогчийн саналыг хэрхэн суудал болгон хуваарилдаг вэ зэрэг сонгуулийн үйл явцын нарийн төвөгтэй мэдээллүүдийг багтаадаг. Энэ нь **“сонгогчдыг мэдээллээр хангах”** гэдэг ойлголтоос илүү өргөн хүрээтэй, илүү цаг хугацаа шаардсан, байнгын буюу тасралтгүй байхад чиглэдэг. Энэ төрлийн мэдээллийг ихэвчлэн сонгуулийн байгууллага болон иргэний нийгмийн байгууллагууд өгдөг. Түүнчлэн, сонгуулийн систем, үйл явц, журамд томоохон өөрчлөлт орох бүрд сонгогч болон анх удаа саналаа өгөх сонгогчдын хувьд сонгогчдын боловсролын хөтөлбөрт шинэчлэгдсэн үзэл баримтлалыг сайтар тусгах шаардлагатай. Сонгогчдын боловсролын хөтөлбөрүүдээс харахад нийтлэг 4 ерөнхий агуулгыг тусгасан байдаг.⁸ Үүнд,

1. **Сонгууль ба ардчилал:** Чөлөөт, шударга сонгуульгүйгээр ардчилал бий болж, бэхжих боломжгүй гэсэн агуулгыг багтаадаг. Сонгогчид бүх нийтээрээ, аливаа нэг айдас, дарамт шахалтгүйгээр чөлөөтэй сонголтоо хийх боломж, нөгөө талаас улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд сонгуулийн кампанит ажлаа явуулах эрх чөлөөтэй байх тухай юм.
2. **Сонгогчийн үүрэг хариуцлага, эрх:** Энэ хэсэгт сонгогчдод сонгуульд оролцох ач холбогдлыг ойлгуулж, сонгуульд оролцох сэдэл, хүсэл зоригийг бий болгодог. Сонгууль нь засгийн эрх мэдлээ хэрэгжүүлэх, төлөөллөө бүрдүүлэх, нөгөө талаас сонгогдсон байгууллага, албан тушаалтнуудтай хариуцлага тооцох боломжтойг ойлгуулдаг.
3. **Таны санал маш чухал:** Сонгуулийн үр дүнг саналаа өгсөн сонгогчоос гадна саналаа өгөөгүй сонгогч хүртэл тодорхойлдог. Ялангуяа хэрэглэж буй сонгуулийн системийн нөлөө нь цөөн тооны саналаар ялж, ялагдах буюу сонгуулийн үр дүнг тодорхойлоход чухал нөлөөтэй. Тиймээс сонгуулийн эцсийн үр дүнг тооцоход санал бүр чухал, үнэ цэнтэй гэдгийг ойлгуулах ёстой.
4. **Таны санал нууц байна:** Сонгогч аливаа нэг айдас, дарамт шахалтаас ангид байх, аль нэг улс

5 Сүүлийн үед энэ ойлголтыг “сонгуулийн боловсрол” гэсэн нэр томъёогоор дүйцүүлж хэрэглэж байгаа тал бий.

6 <https://aceproject.org/main/english/ve/vea02.htm>

7 <https://aceproject.org/main/english/ve/vea03.htm>

8 <https://aceproject.org/main/english/ve/vea02b.htm>

төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн, эсвэл дэмжээгүйн төлөө ямар нэгэн ялгаварлан гадуурхалт, хавчлагад өртөх ёсгүй, таны саналыг танаас өөр хэн ч мэдэх боломжгүй гэдгийг хэлж өгдөг.

“Иргэний боловсрол” гэдэг нь хүний эрхийн, ардчиллын, улс төрийн, төр иргэний хоорондын харилцаа, ардчилсан сонгуулийн талаарх мэдлэг эзэмших, чадвар, хандлагаа хөгжүүлэх үйл явцыг багтаасан, тодорхой бүрэлдэхүүн хэсэг бүхий боловсрол юм. Энэ нь олон нийтийн амьдралд идэвхтэй, хариуцлагатай оролцоход дэмжлэг үзүүлэх ур чадвар, мэдлэг, үнэт зүйлийг хөгжүүлэх үйл явц бөгөөд зөвхөн сонгуулийн мөчлөгтэй хамааралгүй тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Иргэд зөвхөн сонгуулийн үеэр бус улс төрийн үйл явцад тогтмол оролцох ёстой гэж ойлгодог. Гэсэн хэдий ч “сонгогчдыг мэдээллээр хангах”, “сонгогчдын боловсрол” нь иргэний боловсролын томоохон бүрэлдэхүүн хэсэг байж болно. Иргэний боловсролыг сургууль, их сургуулийн системээр, иргэний нийгмийн байгууллагуудаар магадгүй зарим төрийн байгууллагаар дамжуулан явуулж болно, гэхдээ сонгуулийн байгууллага заавал биш.

Эдгээр тодорхойлолт, агуулгаас үзэхэд сонгогчдын боловсрол нь “сонгогчдыг мэдээллээр хангах” ба “иргэний боловсрол” гэсэн хоёр ойлголтын хооронд оршдог болохыг харж болно.⁹ Түүнчлэн сонгогчдыг мэдээллээр хангах, сонгогчдын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх нь сонгуулийн байгууллагын үүрэг, хариуцлага байдаг бол иргэний боловсролыг олгох нь сонгуулийн байгууллагын заавал хэрэгжүүлэх чиг үүрэг биш, сонгогчдын боловсрол нь иргэний боловсролын нэгэн адил урт хугацаанд, тасралтгүй үргэлжлэх үйл явц байдаг бол сонгогчдыг мэдээллээр хангах үйл ажиллагаа нь илүү тухайн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд хамаардаг байна.

Эдгээр ойлголт, нэр томъёоны зааг, ялгааг ийнхүү нарийвчлан тодорхойлох нь манай улсын хувьд сонгогчдод зориулсан хөтөлбөр, агуулга, мэдлэг, мэдээллийн цар хүрээ, онцлогийг тодорхойлоход нэн тустай.

ГУРАВ. СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛЫГ ОЛГОХ НЬ

Улс орнуудад ихэвчлэн сонгуулийн мэргэжлийн байгууллага, төрийн зарим агентлагууд, хүний эрхийн байгууллага, олон улсын болон дотоодын иргэний нийгмийн байгууллагууд зохион байгуулж байна. Аль нэг улс төрийн нам, эсвэл төрөөс шууд хамааралтай, хараат байгууллага сонгогчдод боловсрол олгохоос илүүтэй суртал ухуулга хийх нь элбэг тул үүнээс зайлсхийх хэрэгтэй гэж үздэг.

Сонгогчдын боловсролыг ач холбогдолтой багатай, эсвэл сонголт гэж үзэж болохгүй гэдгийг судлаачид онцолдог. Тиймээс **сонгуулийн байгууллага** нь сонгуулийг хараат бусаар зохион байгуулахаас гадна сонгогчдын боловсрол олгох, сонгогчдыг мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулах үндсэн чиг үүрэгтэй байдаг.

Энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аливаа улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдээс хараат бусаар зөвхөн сонгогчдод сонгуулийн боловсрол олгох зорилгоор явуулдаг.¹⁰ Иймд сонгуулийн байгууллагад сонгогчдын боловсролыг хариуцдаг зохион байгуулалтын бүтэц хэрэгтэй гэж үзээд дэлхийн улс орны сонгуулийн удирдлагын байгууллагууд нь дэргэдээ дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж ажиллуулдаг. Жишээ нь, БНСУ-ын Үндэсний сонгуулийн комисс нь дэргэдээ ардчилал, сонгогчдын боловсрол олгох чиг үүрэг бүхий нэгжтэй. Мөн БНЭУ, ӨАБНУ, Филиппин, Индонези зэрэг улсыг нэрлэж болно. Эндээс үзэхэд сонгогчид зөвхөн өөрийн итгэл үнэмшлээрээ, хараат бус, чөлөөт сонголтоо хийсэн сонгуулийн үр дүнг баталгаажуулж, хуульд заасны дагуу нэгтгэн сонгуулийн үр дүнг гаргадаг байгууллага энэхүү чиг үүргээ хэнээс ч хараат бусаар зохион байгуулах, сонгогчдод сонгуулийн болон ардчиллын боловсрол олгох эрх зүйн болон бусад нөхцөл бүрдсэн эсэх нь үйл ажиллагааны бие даасан байдал гэх ойлголтод хамаардаг байна.¹¹ Сонгогчдын боловсрол, тэдэнд мэдээлэл хүргэх кампанит ажлыг аль нэг нам, эвслээс хамааралгүй, бодитойгоор санхүүжүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж буй эсэх нь сонгуулийн байгууллагын хараат бус, бие даасан байдлын нэг гол шалгуур болж байна.

Сонгогчдын боловсролын хувьд сонгуулийн байгууллага болон төрийн бусад байгууллагын бүрэн эрхийг хуулиар тогтоож өгдөг бол **иргэний нийгмийн байгууллагууд** өөрсдийн зорилго, үйл ажиллагааныхаа хүрээнд энэ асуудалд хувь нэмэр оруулах үүрэг хүлээдэг. Иргэний нийгмийн байгууллагууд сонгогчдын боловсролын урт болон богино хугацааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж, хяналт тавих замаар сонгогчдын боловсролд үнэлж барахгүй хувь нэмэр оруулж байдаг. Түүнчлэн сонгуулийн үйл явцыг ажиглах, хяналт мониторинг хийх, сонгогчдын бүлгүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлуудыг гардан зохион байгуулдаг. Сонгуулийн удирдлагын байгууллагууд иргэний нийгмийн байгууллагууд болох төрийн бус байгууллагыг өөрсдийн хангалтгүй байгаа нөөц, хүрч чадахгүй байгаа орон зайг нөхөх зорилгоор хамтын ажиллагааны стратеги боловсруулж, түншлэн ажилладаг.

Түүнчлэн сонгогчид хаана, хэзээ, хэрхэн саналаа өгөх талаар буюу сонгогчдыг мэдээллээр хангахад **хэвлэл мэдээллийн байгууллага** чухал үүрэг хүлээдэг. Олон нийт сонгуульд оролцож буй бүх талуудын тухай эх сурвалжтай, тэнцвэртэй мэдээллийг хүлээн авахад тусалдаг. Мөн сонгуулийн талаар мэдээлэх, сонгогчдод боловсрол олгох чиг үүргийнхээ хүрээнд сонгуулийн талаар холбогдох мэдээллийг цаг алдалгүй, шуурхай, үнэн зөв мэдээлэх ажлыг хийдэг. Хүмүүст өөрсдийн сонголтоо хийх боломжийг олгохын тулд сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгааны тухай шударга мэдээлэх ёстой. Мөн нэр дэвшигчид гэж хэн болох, тэдний бодлого, мөрийн хөтөлбөр, сонгуулийн байгууллагын үйл ажиллагаа,

10 Д.Бат-Эрдэнэ. Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг. Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал. УБ, 2024 он. 13 дах тал

11 Д.Бат-Эрдэнэ. Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг. Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал. УБ, 2024 он. 13 дах тал

санал авах ажлыг хэрхэн зохион байгуулах, сонгогч саналаа хаана, яаж өгөх, саналын нууцлал хэрхэн хангагдаж байгаа зэрэг мэдээ, мэдээллийг хүргэж ажилладаг байна.

Ялангуяа шилжилтийн болон ардчилал хөгжиж буй улс орнуудын хувьд дотоодын байгууллагын төсвийн болон хүний нөөцөд тулгуурлан сонгогчдод боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй, өргөн хүрээнд, цогц байдлаар явуулахад хүндрэлтэй байдаг тул ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг **гадаадын болон олон улсын байгууллагууд** энэ үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг тусалцаа үзүүлдэг. Эдгээр байгууллагад Европын холбоо, Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Нэгдсэн Үндэсний Байгууллага, Америкийн олон улсын хөгжлийн агентлаг, Канадын олон улсын хөгжлийн агентлаг, Койка буюу БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, олон улсын төрийн бус байгууллагууд болох Ардчиллын төлөө үндэсний сан (NED), Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA) гэх мэт байгууллагуудыг нэрлэж болно.

Сонгогчдын боловсролыг төвийг сахисан, аль нэг улс төрийн намаас хамааралгүй үйл ажиллагаа гэж үздэг хэдий ч сонгогчдын боловсролыг улс төрийн намтай ямар ч холбоогүй гэж ойлгох тал дээр судлаачдын дунд хоёрдмол байр суурь байдаг. Энэ нь нэг талаар буруу ойлголт, яагаад гэвэл **улс төрийн намууд** намын дэмжигч, идэвхтнүүдээ хайхын тулд сонгогчидтой уулзах сонирхолтой байдаг тул сонгогчдод сонгуульд оролцоход шаардлагатай мэдээллээр хангах зардал багатай суваг болж чадна гэж тэд үздэг.¹² Иймд сонгогчдод боловсрол олгоход улс төрийн намыг татан оролцуулах нь чухал. Улс төрийн намууд өөрсдийн гишүүд, дэмжигчдэдээ сонгуулийн талаар мэдээллийг өгөх хэдий ч өөрсдийгөө дэмждэггүй сонгогчдын хэсэгт хүрч ажиллах сонирхолгүй байхгүй. Тэгвэл сонгогчдын энэ хэсэгт өөр бусад улс төрийн намууд хандах боломжтой. Тиймээс улс төрийн намуудаар дамжуулж сонгогчдын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой бөгөөд энэ чиглэлээр стратеги боловсруулах шаардлагатай. Гэхдээ улс төрийн намуудад бүрэн даатгаж болохгүй, төвийг сахисан нам бус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь чухал. Яагаад гэвэл улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанд оролцохгүй сонгогчид байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Аливаа улс оронд сонгогчдын боловсрол олгох хүчин чармайлтын цар хүрээ нь янз бүрийн хүчин зүйлээс хамаарна. Тус улс ардчилсан сонгууль явуулж ирсэн түүхтэй юу, эсвэл шилжилтийн сонгууль хийдэг үү, сонгогч заавал бүртгүүлэх ёстой юу, эсвэл сайн дурын байдаг уу, бүртгэлийг хэн хариуцдаг вэ, төлөөллийг бүрдүүлэх сонгуулийн систем эсвэл санал хураах үйл явцад өөрчлөлт орсон уу? Сонгуулийн үйл явц, улс төрийн байгууллагууд сонгогчдын итгэлийг хүлээж байна уу, сонгуулийн сурталчилгаа нээлттэй, өрсөлдөөнтэй байна уу, өнгөрсөн хугацаанд сонгогчдыг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулсан уу, иргэний боловсрол олгох ажил үргэлжилж байна уу? Эдгээр болон бусад бүх асуултын хариулт нь сонгогчдын боловсролын хөтөлбөрийн мөн чанар, хүртээмжид нөлөөлдөг. Үүнтэй

холбоотойгоор сонгогчдын боловсролын хөтөлбөрийг хэзээ, ямар хугацаагаар хэрэгжүүлэх нь тухайн улс орны онцлог, нийгэм, улс төрийн түүх, засаглалын хэлбэр, бүх нийтийн иргэний боловсролын хөтөлбөр, стратегитай холбоотой. Өмнөх хэсэгт үзсэний дагуу сонгогчдын боловсролын урт хугацааны, байнгын хөтөлбөртэй байх уу, эсвэл сонгогчдын боловсролыг сонгууль бүрд сонгогчдод мэдээлэл өгөхөөр хязгаарлах уу гэдэг нь тухайн улс орны асуудал юм.

Сонгогчдын боловсролын зардлыг эхний ээлжид сонгуулийн байгууллагын буюу тухайн улс орны төрийн санхүүжилтийн хүрээнд авч үзэх шаардлагатай байдаг.¹³ Гэхдээ энэ нөөц бололцоо хязгаарлагдмал тул сонгогчдын боловсролд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд сонгуулийн байгууллагууд илүү их хүчин чармайлт гаргах хэрэгтэй болдог. Зарим улс орны туршлагаас харахад бусад төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай стратегийн түншлэлийг бий болгох замаар энэ нөхцөл байдлыг даван туулж байна¹⁴.

Сонгогчдын боловсролын хөтөлбөрийг нэг улиралд эсвэл сонгуулийн жилд хэдэн удаа хэрэгжүүлж байгаагаас шалтгаалан тухайн улс орон сонгогчдын боловсролын асуудалд хэрхэн анхаардгийг харах боломжтой.¹⁵ Жишээ нь Канад, Австрали, Финланд, Энэтхэг, Их Британи, Франц, Герман зэрэг орнуудад сонгогчдын боловсролын хөтөлбөр бүтэн жилийн турш үргэлжилсээр байдаг. Энэ нь сонгогчдыг хэзээд саналаа өгөхөд болон сонгуульд оролцоход бэлэн, идэвхтэй байхад тусалдаг. Харин Хятад, Алжир, Саудын Араб, Мьянмар, Камерун зэрэг улсуудад сонгогчдын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэггүй байна. Энэ нь тухайн улсын засаглалын хэлбэртэй холбоотой буюу социалист, нэг намын тогтолцоотой холбоотой. Мөн Ливи, Казакстан, Нидерланд, Индонез зэрэг бүгд найрамдах засаглалтай зарим орнуудад ч сонгогчдын боловсролын талаарх мэдлэг, ойлголт дутмаг, зарим улс орнуудад зөвхөн сонгуулийн үеэр л ийм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ /МОНГОЛ УЛСАД/

НЭГ. БОДИТ БАЙДАЛ ЯМАР БАЙНА ВЭ?

Сонгуулийн мэргэжлийн, удирдлагын байгууллага нь сонгогчдын боловсролын хөтөлбөрийг сонгодог утгаар нь хэрэгжүүлдэггүй, харин энэ орон зайг **элжит сонгуулийн жил “сонгогчдод мэдээлэл хүргэх” төдийгөөр ойлгож, орлуулж ирсэн** гэж хэлэхэд бодит байдлаас хол зөрөхөөргүй байна.

Сонгогчдын боловсрол олгох асуудлыг хэн хариуцах

12 <https://aceproject.org/main/english/ve/vea03b.htm>

13 <https://aceproject.org/main/english/ve/ve10.htm>

14 Мөн тэнд

15 <https://gogo.mn/r/wjyek>

ёстой вэ? Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, **сонгогчдын боловсролыг дээшлүүлэх**, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах” асуудлыг Хорооны бүрэн эрхэд хамааруулсан тул Сонгуулийн ерөнхий хороо энэ чиг үүргийг хэрэгжүүлж байна. Сонгуулийн төв байгууллагын хувьд энэ чиг үүргийнхээ хүрээнд сонгуульд оролцогч бүх талыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, сонгогчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийг шударга, ил тод, нээлттэй, элдэв будилаангүй явуулах, сонгуулийн ажилд иргэний нийгмийн хийгээд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангахад анхаарч ирсэн¹⁶ хэдий ч энэ нь зөвхөн ээлжит сонгуулийн жилийн хүрээнд л хэрэгжиж байна.

Сонгогчдод боловсрол олгох үйл ажиллагааны онцлог нь тасралтгүй үргэлжлэх, агуулгын хувьд өргөн, цогц үйл ажиллагаа гэдгийг өмнөх хэсэгт авч үзсэн. Сонгуулийн төв байгууллага зөвхөн “сонгогчдод мэдээлэл хүргэх” байдлаар чиг үүрэг нь хязгаарлагдаж байгаа нь дараах шалтгаантай холбоотой байж болох юм.

- 1. Хууль, эрх зүйн талаас:** Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 66.12-д “Сонгуулийн ерөнхий хороо сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцуулах талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлж болно”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 62.12-д “Сонгуулийн ерөнхий хороо сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцуулах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэжээ. Энэ нь сонгуулийн байгууллагын энэ чиг үүргийг зөвхөн сонгуульд сонгогчдыг оролцуулах төдийгөөр хязгаарладаг.
- 2. Институтын чадавх талаас:** Сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн агуулга, мөн чанарын талаарх мэдээлэл, сургалт буюу сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд тогтмол явуулж чадаж байгаа эсэх нь бие даасан, хараат бус байдлын шалгуур болж байдаг. Энэ шалгуурыг ийм чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжтэй эсэхээр нь авч үздэг. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т зааснаар Хороо өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах ажлын албатай байх бөгөөд түүний бүтэц, ажиллах журмыг Хороо батална гэж хуульчилсны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны тогтоолоор Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтсийг 5 орон тоотойгоор байгуулсан байна. Мөн 2022 оны тогтоолоор уг хэлтсийг Мэдээлэл, судалгаа, сургалтын төв болгон 12 орон тоотой байхаар өөрчлөн байгуулсан хэдий ч өнөөдрийн байдлаар 8 хүний нөөцтэйгөөр ажиллаж байна. Энэ төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргээс харахад “төсөл, хөтөлбөрийн хүрээнд сонгогчдод сонгуулийн боловсрол олгох сургалт”

16 Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй. Олон улсын онол, практикийн бага хурлын эмхэтгэл, УБ. 2022 он. 13 дахь тал



зохион байгуулна гэжээ.¹⁷ Хэдийгээр тус төв нь үйл ажиллагаагаа тодорхой хугацаанд буюу сонгуулийн жилд идэвхтэй явуулж байгаа боловч дээр дурдсанаар сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл явц нь тасралтгүй, өргөн хүрээнд үргэлжлэх цогц үйл ажиллагаа гэж харах юм бол энэ нь бүтэц, орон тооны хувьд хангалттай биш. Сонгогчдын боловсрол олгох үйл ажиллагаа их хэмжээний бэлтгэл, зохион байгуулалт, мэргэжил, ур чадвар, хүний нөөц шаарддаг нарийн төвөгтэй, үйл явц юм.

3. **Зардал, санхүүжилтийн талаас:** Сонгогчдын боловсролын төсөв, санхүүжилтийн хүрэлцээгүй, хангалтгүй байдал нь томоохон шалтгаан болж байна. Сонгуулийн төв байгууллагын "мэдээлэл, сурталчилгааны зардал" гэсэн зүйл ангитай төсвөөс энэ асуудлаа зохицуулдаг ч энэ нь маш бага. Зөвхөн сонгуулийн жил л төсөвтэй байхаас биш сонгуулийн бус үед ийм зориулалт бүхий төсөв байхгүй. Сонгуулийн төв байгууллага төсөв, санхүүгийн хүртээмжгүй байдлаас болж сонгогчдод боловсрол олгох ажлаа зөвхөн сонгуулийн жил, сонгууль зохион байгуулах төсөвтөө суулгасан санхүүжилтээр хязгаарлаж ирсэн. Сонгуулийн үед сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр сонгуулийн хууль тогтоомжид заасан байдаг. Тухайлбал, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1.7-д "сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээ, түүнд холбогдох тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээний зардал", Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9.1.7-д "сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал", Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1.7-д "сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал" гэж заасан байдаг.

Манай улсад **сонгогчдод боловсрол олгох чиг үүргийг "үндсэн чиг үүргийн бус байгууллага"-ууд хэрэгжүүлж ирсэн.** Хэдийгээр энэ үйл явцад оролцож буй дор дурдсан байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны зорилго, чиглэлийн хүрээнд нийгэмд хүлээсэн үүргийнхээ дагуу төрийн хэрэгжүүлэх энэ чиг үүргээс хуваалцаж байгаа ч тэдэнд хангалттай эрх мэдэл, тогтвортой бүтэц, хүрэлцэхүйц нөөц, чадавх зарим тохиолдолд шаардлагатай ур чадвар хангалттай биш гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Нөгөө

талаас сонгогчдын боловсролын хөтөлбөр нь тухайн улсын түүх, ардчиллын түвшин, улс төр, эдийн засаг, нийгмийн орчин, иргэний болон ардчиллын боловсролын үндэсний хөтөлбөр, хэрэгжилт зэргээс хамаарч тухайн орны онцлогийг шингээсэн урт хугацаанд, тогтвортой, цогц байдлаар хэрэгжих үндсэн онцлог талаас нь авч үзэх юм бол энэ нь тодорхой хувь нэмэр болж байгаа хэдий ч цогцоор шийдэх шийдэл биш гэдэг нь тодорхой юм.

- **Төрийн бус байгууллага:** Төрийн бус байгууллагууд олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдээс санхүүжилт босгож сонгогчдын боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. Манай улсын хувьд сонгогчдын боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд бусад салбарынхтай харьцуулбал маш цөөн байдаг. Тэдэнд хамрах хүрээний хувьд хангалттай биш ч урт болон богино хугацааны хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн олон санаачилга, туршлага бий. Энд Нээлттэй нийгэм форум, Сонгогчдын Боловсрол Төв, Бодлогод залуусын хяналт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг нэрлэж болно.
- **Олон улсын байгууллага:** Өмнөх хэсэгт дурдсан шиг олон улсын засгийн газрын болон төрийн бус байгууллага, элчин сайдын яамд сонгогчдын боловсролд чиглэсэн сургалт, судалгаа, олон нийтийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн кампанит ажлуудыг багтаасан олон тооны санаачилгыг дэмжиж, санхүүжүүлж ажиллаж байна. Тухайлбал, Америкийн нэгдсэн улсын олон улсын хөгжлийн агентлаг (USAID), БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA), Нэгдсэн үндэсний байгууллага (UNDP), НҮБ-ын Ардчилал сан (UNDEF), Бүгднайрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI), Конрад Аденауэрын сан, Азийн сан гэх мэт.
- **Хэвлэл мэдээллийн байгууллага:** Энэ чиглэлийн байгууллагууд зөвхөн сонгуулийн үеэр сонгогчдын боловсролд чиглэсэн тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, нийтлэл нэвтрүүлэг цацдаг. Энэ нь тэдний хуулиар хүлээсэн үүрэгтэй холбоотой байдаг. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.15, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41.15, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45.15-д "Радио, телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй" гэж заасан байдаг.

Сонгогчдод бүх талаар ойлгомжтой, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь сонгуулийг зардал багатай, цаг хугацаа хэмнэн явуулахад тустай бөгөөд сонгогчдын боловсрол сайн байх тусам сонгуулийн ирц бүрэн байдаг. Иймд сонгууль дахь иргэдийн оролцоо нь сонгуулийн эрх зүй, сонгуулийн тогтолцооны үр дүнгийн гол шалгуур болдог¹⁸, мөн тухайн

17 Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн танилцуулга, 2 дох нүүр

18 Б.Чимид. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу?. Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IV. УБ. 2011 он, 44 дэх тал

засаг төр, сонгуулийн үйл явцад хэр итгэж байгааг харуулдаг. Хэдийгээр сонгуулийн ирцэд эдийн засаг, нийгэм, соёл, хууль эрх зүйн болон хувь хүний хүчин зүйлүүд нөлөөлдөг¹⁹ ч ардчилал хөгжсөн болон шинээр хөгжиж буй орнуудад сонгогчдын ирц, оролцоогүйгээр ардчиллыг бодитоор авч үзэх боломжгүй²⁰ гэж үзэх нь ч бий. Энэ талаас нь үзвэл бидний санаа зовоож буй асуудал нь иргэдийн улс төрийн идэвх, тухайлбал **сонгууль дахь ирц, оролцоо сонгууль бүрт буурах хандлага**²¹ юм. Ялангуяа залуу сонгогчдын ирц маш бага байна. Монгол Улсын нийт сонгогчдын талаас илүү хувь нь 20-39 насны залуу сонгогчид бөгөөд тэд улс төрийн идэвхгүй байдлаа "улс төрийн нам, улс төрчдөд итгэдэггүй", "найдар төрдөггүй" гэж тайлбарласан байдгийг²² анхаарах ёстой. 2021 онд Конрад Аденауэрын сангийн дэмжлэгээр "Нийгэм, улс төрийн боловсрол" төрийн бус байгууллагаас хийсэн "Z үеийн улс төрийн оролцоо" судалгааны дүнгээс харахад "залуучуудын улс төрийн оролцооны түгээмэл хэлбэр нь сонгуульд оролцож саналаа өгөх" байдлаар илэрч байна. Судалгаанд оролцсон залуучуудын 95 хувь нь сонгуульд оролцох нь "маш чухал", "чухал", харин 80.2 хувь нь удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгнө гэж хариулжээ. Бодит байдал дээр 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 18-19 насны залуучуудын 56.5 хувь, 20-24 насны залуучуудын 43.7 хувь, 25-29 насны залуучуудын 46.3 хувь нь саналаа өгсөн байна. Залуу сонгогчид сонгуульд саналаа өгөхийг чухал гэж үзэж байгаа боловч саналаа өгөхдөө хойрго байгааг эндээс харж болно. Тэдний сонгуулийн талаар авч буй мэдээлэл, хүртээмжийн талаар асуусан асуултад 62 хувь нь мэдээлэл "маш сайн авдаг" гэж хариулжээ. Энэ нь сүүлийн хэд хэдэн удаагийн сонгуульд төрийн бус байгууллагууд олноороо залуу сонгогчдыг сонгуульд оролцуулах өргөн хүрээний, үндэсний томоохон кампанит ажлуудыг зохион байгуулсантай холбоотой байж болох юм. Залуучууд "сонгуульд оролцох нь чухал" гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа ч сонгуулийн тухай хууль, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн тойрог, нэр дэвшигчдэд ямар шаардлага тавьдаг зэргийг мэддэггүй учраас сонгуулийг төдийлөн тоодоггүй, саналаа өгдөггүй талаар тус судалгааны тайланд онцлон тэмдэглэжээ.²³ Энэ нь сонгогчдыг сонгуулийн үеэр мэдээллээр хангахаас илүү сонгогчдын боловсролын хөтөлбөр чухал гэдгийг харуулж байна.

ХОЁР. ОДООГИЙН ОЛОЛТ АМЖИЛТ ЮУ БАЙНА ВЭ?

1.Бидэнд сонгогчдын боловсролын чиглэлээр бий болгосон **хамтын ажиллагаа, түншлэл, туршлага** байна.

- » Сонгогчдын боловсролын талаар болон сонгогчдод сонгуулийн үеэр мэдээлэл өгөх ажлыг зөвхөн

сонгуулийн төв байгууллага биш төрийн бусад байгууллага /ХЭҮК, Иргэний бүртгэлийн байгууллага гэх мэт/, төрийн бус байгууллага, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудыг оролцуулж энэ чиглэлийн хөтөлбөрийн цар хүрээ, хамтын ажиллагаа, санхүүжилтийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Сонгогчдын Боловсрол Төвөөс Сонгуулийн ерөнхий хороотой "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг 2022 онд байгуулсан. 2012 оноос хойш ээлжит сонгууль тус бүрд "Сонгогчийн лавлах утас" ажиллуулж, олон нийтийн кампанит ажлыг хамтран зохион байгуулж байна. Түүнчлэн Нээлттэй нийгэм форум, Азийн сан, "Альтернатив төв", Сонсголгүй иргэдийн мэдээллийг дэмжих "Бүтээмж төв", Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, Азийн сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр зэргийг дурдаж болно.

- » Төрийн бус байгууллагууд сонгогчдын боловсролын чиглэлээр өргөн хүрээнд, урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж чадахгүй байгаа ч өөрсдийн үйл ажиллагаа, зорилго, чиглэлийн хүрээнд тодорхой хувь нэмэр оруулж, сонгуулийн төв байгууллагад тус дэм болсоор байна. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үйл явцад оролцуулах талаар бодитой үр дүн гаргаж чадсан²⁴ талаар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас онцлон тэмдэглэсэн байдаг.

2.Бидэнд сонгогчдын боловсролын асуудлыг нэн тэргүүний зорилтоо болгосон **сонгуулийн төв байгууллагын амлалт, чин хүсэл** байна. Сонгуулийн төв байгууллага одоог хүртэл сонгуулийг удирдан зохион байгуулах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж, энэ чиглэлээр олсон үр дүн, ололт амжилт нь дэлхийн олон улс орнуудад авч хэрэгжүүлэх сайн туршлага болж байна. Харин одоо орхигдож ирсэн нэг үндсэн чиг үүрэг болох сонгогчдын боловсролын асуудлыг ийнхүү хүлээн зөвшөөрч, шинээр авч үзэх хүсэл эрмэлзэл нь итгэл найдвар болж байна.

- » Монгол Улсад байнгын ажиллагаатай сонгуулийн төв байгууллага үүсч хөгжсөний 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан "Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй" онол, практикийн бага хурлын үеэр Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран "Ардчилсан сонгууль – Туршлага, сорилт" илтгэлдээ "Ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, **сонгогчдын боловсролыг дээшлүүлэх**, энэ талаар сургалт, судалгааны ажлыг өргөн цар хүрээтэй явуулах"-ыг сонгуулийн төв байгууллага **цаашдын зорилтоо болгон тодорхойлж байгааг онцлон тэмдэглэсэн** болно. Түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир тус хурлыг хааж хэлсэн үгэндээ "...бид **сонгогч**

19 Democratic elections: Today and Future. International conference, UB. 2022, page 59.

20 <https://aceproject.org/main/english/ve/ve10.htm>

21 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль 59 хувь, 2024 оны УИХ-ын сонгууль 69 хувь, Орон нутгийн Хурлын сонгууль 53 орчим хувь байсан.

22 Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй. Олон улсын онол, практикийн бага хурлын эмхэтгэл, УБ. 2022 он. 33 дахь тал

23 "Z үеийн улс төрийн оролцоо" судалгааны тайлан. Нийгэм, улс төрийн боловсрол ТББ, УБ, 92 дох тал.

24 Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй. Олон улсын онол, практикийн бага хурлын эмхэтгэл, УБ. 2022 он. 37 дахь тал



олондоо хандсан үйл ажиллагаа явуулж, тэдний эрх, эрх чөлөөг хангаж ажиллах нь чухал гэж дараагийн 10 жилийн үйл ажиллагааны чиглэлээ танилцуулсан.

- Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т зааснаар Хороо өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах ажлын албатай байх бөгөөд түүний бүтэц, ажиллах журмыг Хороо батална гэж хуульчилсны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны тогтоолоор Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтсийг 5 орон тоотойгоор байгуулсан байна. Мөн 2022 оны тогтоолоор уг хэлтсийг Мэдээлэл, судалгаа, сургалтын төв болгон 12 орон тоотой байхаар өөрчлөн байгуулж хариуцах эзэнтэй болгох эхлэлийг тавьж байна.

3.Энэ чиг үүргийг дан ганц сонгуулийн байгууллага биш харин сонгуульд оролцдог байгууллагын нэг болох **улс төрийн намд хуулиар олгосон нь** сонгогчдод олгох боловсролын хөтөлбөрүүдэд томоохон дэмжлэг болно гэсэн хүлээлт байна. Улс төрийн намын тухай шинэ хуулиар сонгогчдод сонгуулийн болон улс төрийн боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлэхэд улс төрийн нам хэрхэн оролцохыг тодорхой болгож өгсөн. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуульд:

- Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3:** Нам нь Үндсэн хуульт байгуулал, ардчилсан тогтолцооны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд "иргэдийн улс төрийн боловсрол, идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих" чиг үүрэгтэй гэжээ.
- Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1:** Намын бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий бодлогын судалгааны байгууллага намын дэргэд ажиллахаар

тусгасан.

- Хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.2: Намд олгосон төрийн санхүүжилтийн талаар "төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах"-д зарцуулахаар зориулалтыг нь зааж өгсөн байна.

4.Бидэнд 2012 оноос эхлэн мэдээллийн технологийг сонгуулийн үйл явцад нэвтрүүлж үлэмж их ололт бий болсны нэг нь сонгуулийн үйл явц, сонгуульд оролцогч талууд болон сонгогчидтой холбоотой **их хэмжээний дата мэдээллүүд бий болсон** явдал юм.

- Эдгээр дата мэдээллийг бүх оролцогч талуудад хүртээмжтэй болгосноор оролцогч талуудын шийдвэр гаргалтад суурь мэдээлэл болох учиртай. Ялангуяа төрийн бус байгууллагууд, залуу сонгогчид болон улс төрийн оролцоонд жендэрийн тэгш байдалд чиглэсэн олон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь сонгуулийн боловсролд чухал үүрэг гүйцэтгэдэг. Сонгуулийн дата мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээллийн форматаар хүргэснээр төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн, хүртээмж нэмэгдэж, шууд болон шууд бус байдлаар сонгогчдын боловсрол, сонгуулийн ирц, оролцоо нэмэгдэх боломжтой.²⁵ Энэ чиглэлээр Сонгуулийн ерөнхий хороо Тунгаахуй өгөгдлийн урлантай хамтран "Өгөгдлийн дүрслэлийн нээлттэй сан"-г бий болгон 1990 оноос хойшхи сонгуультай холбоотой өгөгдлийг байршуулсан байна. Энэ нь сонгуулийн өгөгдлийг ойлгомжтой, хүртээмжтэй, нээлттэй, ил тод болгож судалгааны эргэлтэд оруулахад томоохон хувь нэмэр болох юм.

²⁵ Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй. Олон улсын онол, практикийн бага хурлын эмхэтгэл, УБ. 2022 он. 42 дахь тал

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ЦААШИД ХЭРХЭХ ВЭ (САНАЛ ЗӨВЛӨМЖ)

Сонгогчдын боловсролын үр дүнтэй хөтөлбөрийг боловсруулж, амжилттай хэрэгжүүлэх зайлшгүй чухал хүчин зүйл нь төрийн өөрийнх нь хүсэл зоригоос хамаардаг гэж хувьдаа үздэг. Нөхцөл байдлыг сайжруулах хамгийн эхний алхам бол сонгуулийн төв байгууллага сонгогчдын боловсролын чиглэлээр манлайллаа байнга нэмэгдүүлэх явдал гэж харж байна. Түүнчлэн сонгогчдын боловсролыг одоо байгаа түвшнээс ахиулахын тулд иж бүрэн, цогц байдлаар асуудалд хандах ёстой. Иж бүрэн хандлага гэж юуг хэлж байна вэ гэхээр юуны түрүүнд хэн энэ асуудлыг хариуцах вэ, хариуцах байгууллагын бүрэн эрх, хараат бус байдал, хүний болон санхүүгийн, мэргэжлийн, ур чадварын нөөцийн хангалттай, хүртээмжтэй байдлыг яаж хангах, сонгогчдын боловсролын хөтөлбөрийн агуулга, хэн боловсруулж, хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавих вэ, санхүүжилтийг хаанаас гаргах вэ зэрэг цаг хугацаа, хөрөнгө хүч, улс төрийн шийдэл, эрх зүйн орчин гэсэн бүхий л талаас нь авч үзэх шаардлагатай байна.

Дараах арга хэмжээг нэн тэргүүнд авах нь зүйтэй байна. Үүнд,

1. Сонгуулийн төв байгууллагын хуулийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах замаар сонгогчдын боловсролтой холбоотойгоор хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, санхүүжилтийг тодорхой болгох шаардлагатай. Энэ хүрээнд:
 - » сонгогчдын боловсрол болон сонгогчдыг мэдээллээр хангах чиглэлээр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгох, эдгээр ойлголтуудын зааг ялгааг тодруулж, үүнтэй уялдсан онцлог зохицуулалтыг авч үзэх
 - » энэ чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулах, хараат бус, бие даасан байдлыг хэрхэн хангах, сонгогчдын боловсролын нарийн төвөгтэй байдлыг харгалзан хүний болон санхүүгийн, мэргэжлийн, ур чадварын хангалттай нөөцтэй байх боломжийг бүрдүүлэх.

2. Улс төрийн намын тухай хуулийг хэрэгжүүлэхэд улс төрийн намуудтай нягт хамтран ажиллах боломжтой. Энэ хүрээнд:
 - » Улс төрийн намуудад өөрсдийн гишүүд, дэмжигчдээ сургахад нь зориулж, сонгогчдын боловсролын хөтөлбөр, сургалтын гарын авлага боловсруулж, мэдлэг мэдээллээр хангах
 - » Улс төрийн намуудад сонгогчдын боловсролоор мэргэшсэн сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх
3. Сонгуультай холбоотой бий болсон дата мэдээллүүдэд боловсруулалт хийж, сонгууль бүрийн дараа оролцоо багатай сонгогчдын насны болон газар зүйн бүлгүүдийг ангилан тэдэнд тохирсон тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх замаар сонгогчдын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа анх удаа саналаа өгөх, залуу сонгогчдод чиглэсэн урт болон богино хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.
4. Сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл явц нь тасралтгүй, өргөн хүрээнд үргэлжлэх цогц үйл ажиллагаа талаасаа зөвхөн сонгуулийн байгууллагын төсвийн болон хүний нөөцөд тулгуурлан зохион байгуулахад хүндрэлтэй байдаг тул ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын болон олон улсын байгууллага, дотоодын иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаагаагаа цаашид үргэлжлүүлэх шаардлагатай.
5. Сонгогчдын боловсролыг сайжруулахад инноваци, шинэлэг арга зүйг баримтлах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч сонгуулийг зохион байгуулах, сонгуулийн үйл явцад мэдээллийн технологийг хэрэглэх тал дээр олж авсан одоогийн ололт, амжилтаа яаж ашиглах вэ гэдгийг тусгайлан анхаарч үзэх шаардлагатай.
6. Одоог хүртэлх бидний туршлагаас харахад сонгогчдын боловсролын хөтөлбөрүүд нь төлбөр өндөртэй байна. Иймд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн хэрэгслийг бага эсвэл үнэ төлбөргүй ашиглах замаар сонгогчдын боловсролын хөтөлбөрийн зардлыг бууруулах боломжийг судалж үзэх зүйтэй.



“ҮНДСЭН ХУУЛЬТ АРДЧИЛЛЫГ ХАМГААЛАХАД СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ”

Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал



**“THE ROLE OF THE ELECTORAL MANAGEMENT BODY IN
PROTECTING CONSTITUTIONAL DEMOCRACY”**
an international theoretical and practical conference